АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

2022.01.29

| № | Зорилт, арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | | Зорилт от түвшин | Хүрсэн түвшин | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Он | Түвшин | | | |
| 1. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | | | |
| 1 | Зорилго Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлын үед боловсролын үйл ажиллагааг тасралтгүй хүргэж, тахлаас үүдэлтэй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлын хангалт 2019 онд 80.0 хувь байсныг 2024 онд 90.0 хувьд хүргэнэ. | 2021-2024 | Хандив тусламж 2,199.2 | Гамшгийн үеийн бэлэн байдлын нөөцийн хангалтын хувь | 2020 | 80 | 82 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний гамшгийн үеийн бэлэн байдлын нөөцийн хангалт 85,0 хувьд хүрсэн. | 100 |
| | | | | Теле хичээл тогтмол судлан үзэж буй сурагчдын эзлэх хувь | 2020 | 59.1 | 65 | Боловсролын салбарын 2020-2021 оны хичээлийн жилийн сургалтын үйл ажиллагаа танхим болон цахим хэлбэрээр явагдаж, теле хичээлд 8463 суралцагчийн 88 хувь тогтмол хамрагдсан байна. | |
| 1.1 | Зорилт Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээний санхүүжилтыг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | Хандив тусламж 2,199.2 | Нэмэгдсэн санхүүжилтийн хэмжээ (сая.төг) | 2020 | 105.2 | 385.0 | Коронавирусын халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээнд 4,840,0 сая төгрөгийн санхүүжилт авч өнгөрсөн оны мөн үеэс 80 хувиар өссөн байна. | 100 |
| 1.1.1 | Арга хэмжээ: Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх. | 2021-2024 | - | Эрсдэлт бүлгийн хүн амын хамрагдалтын хувь | 2020 | 81 | 83.5 | Эрсдэлт бүлэг буй 2-11 насны хүүхдүүд болон, жирэмсэн эхчүүд нийт 4730 эх, хүүхдийг улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтанд бүрэн хамруулсан. Хамрагдалт 100 хувь | 100 |
| 1.1.2 | Арга хэмжээ: Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас урьдчилан сэргийлэх, тандалтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, хариу арга хэмжээний бэлэн | 2021-2024 | Улсын төсөв 200.0 хандив 740.0 | Гамшгийн үеийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 2020 | 78 | 80 | Хяналтын монитор, зөөврийн дижитал рентген аппарат, пульс оксиметр, амьсгал тоологч гэх мэт 14 нэр төрлийн тоног төхөөрөмжийг нийт 4.9 сая төгрөгний санхүүжилтээр авч, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байдлыг хангах. | | | | | | | тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлсэн. Гамшгийн үеийн Тоног төхөөрөмжийн хангалт 85,3 хувьтай байна. | |
| | | | УТ 1,190.2 | Гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгсэлийн нөөцийн хангалтын хувь | 2020 | 50 | 55.3 | Аймгийн эрүүл мэндийн салбарт 1.190.2 сая төгрөгний үнэ бүхий хамгаалах хувцас хэрэгсэл, урвалж, оношлуур, ариутгал халдваргүйтгэлийн бодисыг авч COVID-19 вирусын цар тахлын дэгдэлт, гамшгийн үеийн нөөцийн бэлэн байдлыг нэмэгдүүллээ. Аймгийн хэмжээнд нийт “Коронавируст халдвар”-ын 9948 тохиолдол бүртгэгдэн, тандалт судалгааг хийн нийт 3383 иргэнийг тусгаарлан, 3-4 удаагийн давтан хяналтын шинжилгээнд хамруулсан. Гамшгийн үеийн эм, эмнэлгийн хэрэгсэлийн нөөцийн хангалт 88.5 хувьтай байна. | |
| 1.1.3 | Арга хэмжээ: Нэгдсэн эмнэлгийг коронавируст халдвар/covid-19/-ын оношилгооны PCR шинжилгээний тоног төхөөрөмжөөр хангах. | 2021 | Улсын төсөв 173.0 | тоног төхөөрөмжийн тоо | 2019 | 0 | 1 | Аймгийн нэгдсэн эмнэлэгт молекул биологийн лабораторийг түшиглэн Эрүүл мэндийн яамнаас орон нутагт ПГУ(PCR) шинжилгээний / BioRad CFx96, Extraction - Allsheng Nyma96 аппарат/-ыг шийдвэрлэж үйл ажиллагаа нь эхлүүллээ. Коронавирусын халдвар илрүүлэх PCR шинжилгээг 4048 хүнд хийгээд байна. | 100 |
| 1.1.4 | Арга хэмжээ: Гамшгийн үед ажиллах мэргэжлийн анги, бүрэлдэхүүнийг сурган дадлагажуулах. | 2021-2024 | - | Сурган дадлагажуулсан бүрэлдэхүүний тоо | 2020 | 50 | 55 | Монгол улсын Шадар сайдын “Үнэлгээ хийх аргачлал батлах тухай” тушаалын дагуу болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах явцын үнэлгээг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | аймгийн хэмжээнд хийж Улсын онцгой комисст хүргүүллээ. Улсын онцгой комиссоос аймгийн эмнэлэг, эрүүл мэндийн төвийн мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн 80 эмч мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулсан. | |
| | | | - | Сурган дадлагажуулсан мэргэжлийн ангийн тоо бүрэлдэхүүний тоо | 2020 | 1 | 2 | Гамшгийн үед ажиллах мэргэжлийн 2 анги, бүрэлдэхүүнийг зохион байгуулалтанд оруулж, бэлэн байдлыг хангаж ажиллаа. Коронавируст халдварын үед ажиллах шуурхай хариу арга хэмжээний 5 багийг томилон эмнэлэг дэлгэх, эмнэлэг нүүлгэн шилжүүлэх нэгдсэн төлөвлөгөөг батлан хэрэгжүүллээ. Төлөвлөгөөний хэрэгжилт 80.9 хувьтай байна. | |
| 1.1.5 | Арга хэмжээ: Цахим шилжилт, туршилтыг ерөнхий боловсролын 8 сургуульд нэвтрүүлэх | 2021-2024 | - | Нэвтрүүлсэн сургуулийн тоо | 2020 | 0 | 2 | Гурвансайхан, Сайнцагаан сумын Эрдмийн Далай Цогцолбор сургуулиуд БШУЯ-ны Цахим шилжилт төсөлд хамрагдан www.amjilt.com, www.ubt.mn сайтуудыг сургуулийн хэмжээнд ашиглан нийт 90 багш, 1845 сурагчид хамрагдан цахим орчинд мэдээ, мэдээллийг түгээн, сургалт үйл ажиллагаа зохион байгуулах боломж бүрдлээ. | 100 |
| 1.1.6 | Арга хэмжээ: Багш нарыг зөөврийн компьютерээр бүрэн хангах | 2021-2024 | 132.0 УТ | зөөврийн компьютерээр хангагдсан багш нарын хувь | 2020 | 80 | 85 | "Эх соёл эх үндэс" хөтөлбөрийн хүрээнд 41 сургууль, цэцэрлэг тус бүр 1, Хүмүүнлэг сургууль 25 нийт 76 зөөврийн компьютерээр хангаж аймгийн хэмжээнд нийт багш нарын 90 хувь хангагдлаа. | 100 |
| 1.1.7 | Арга хэмжээ: Цахим платформ ашиглан багш сурагчдыг сургалт арга | 2021-2024 | 3.0 ОНТ | Арга хэмжээний тоо | 2020 | 2 | 4 | Цэцэрлэг, ЕБС-ийн багш нарын заах аргыг дээшлүүлэх, цахим орчинд ажиллах ур чадварыг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хэмжээнд хамруулах | | | | | | | сайжруулах, зөвлөн туслах, мэргэжлийн багийг чадваржуулах, эрдэм шинжилгээний баг хурал зэрэг 30 удаагийн сургалт, арга хэмжээг цахимаар зохион байгуулж, давхардсан тоогоор аймгийн 523 багш нар 100% хамрагдсан үзүүлэлттэй байна. | |
| | | | | сурагчдын хамралтын хувь | 2020 | 55 | 60 | БСУГ, ЕБС-иудаас зохион байгуулсан ЭЕШ-ын сургалт сорил, “Дундговь боловсрол-2021 EXPO” арга хэмжээ, хичээл сургалтын үйл ажиллагаа, уралдаан тэмцээнийг цахим платформ ашиглан зохион байгуулж, аймгийн нийт хүүхдийн 80 хувь оролцсон. | |
| **2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО** | | | | | | | | | |
| 2 | Зорилго Хүний хөгжлийг дэмжин иргэдийн ажилтай, орлоготой байх нөхцлийг бүрдүүлэн, хүний хөгжлийн үзүүлэлт 2019 онд 0.689 байсныг 2024 онд 0.719 хувьд хүргэнэ. | 2021-2024 | 16520.5 | Хүний хөгжлийн үзүүлэлт (индекс) | 2019 | 0.689 | 0.696 | 2020 оны хүний хөгжлийн индексийн статистик үзүүлэлтээр 0,715-д хүрсэн. | 100 |
| **2.1. Эрүүл мэнд** | | | | | | | | | |
| 2.1 | Зорилго Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж хүн амын дундаж наслалт 2019 онд 74.03 байсныг 2024 онд 75-д хүргэнэ. | 2021-2024 | - | Хүн амын дундаж наслалт (тоо) | 2020 | 74.23 | 74.25 | Аймгийн хүн амын дундаж наслалт 74.61 байна. | 100 |
| | | | | эрэгтэй, эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүү (тоо) | 2020 | 7.94 | 7.8 | Эрэгтэй хүний дундаж наслалт 71.48, эмэгтэй хүний дундаж наслалт 79.28 болж дундаж наслалтын зөрүү 7.54 байна. | |
| 2.1.1 | Зорилт Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэлт 2019 онд 57.8 | 2021-2024 | ЭМД-ын сан | Эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалтын хувь | 2019 | 57.8 | 60.2 | Зонхилон тохиолдох халдварт бус өвчлөл артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгт 12140 хүн хамрагдахаас 9844 /81,1%/, чихрийн шижин хэв шинж-2-ын эрт | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байсныг 2024 он гэхэд 67.4 хувьд хүргэнэ. | | | | | | | илрүүлэг үзлэгт 12769 хүн хамрагдахаас 10029 /78,5%/, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг шинжилгээнд 2613 хүн хамрагдахаас 1665 хамрагдаж /63,92%/, хөхний өмөнгийн эрт илрүүлэг үзлэгт 10226 хүн хамрагдахаас 6467 /63,2%/ иргэнийг тус тус хамруулж, шинээр артерийн гипертензийн 34, чихрийн шижин хэв шинж -2-ийг 4 өвчлөлийг тус тус илрүүлэн хяналтанд авч эмчилгээнд хамруулллаа. Өмнөх оны мөн үеэс артерийн гипертензийн эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 7,7%-иар, чихрийн шижин хэв шинж-2-ын эрт илрүүлэг үзлэгийн хамрагдалт 7,7%-иар өссөн бол хөх, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэг шинжилгээний хамрагдалт 15,5 хувиар, хөхний өмөнгийн эрт илхүүлэг үзлэг 10,6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна. Халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт хамрагдалтын дундаж хувь 64,95 болсон байна. | |
| 2.1.1.2 | Арга хэмжээ: Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгож, “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн”, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага”-ын тоог нэмэгдүүлэх. | 2021-2024 | УТ 1.3 | Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, иргэний тоо | 2019 | 29 | 35 | “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олон, өрх-гэр”, “Эрүүл мэндээ дээдлэгч иргэн” шалгаруулах журмыг гарган “Эрүүл мэндийг дэмжигч иргэн” 15, “Эрүүл өрх, гэр бүл” 10, “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олон” 10 тус тус шалгаруулан өргөмжлөл, мөнгөн шагналаар урамшууллаа. Нийт эрүүл мэндийг дэмжигч байгууллага, иргэний тоо 35 болсон. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.1.3 | Арга хэмжээ: Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт, зорилтот бүлгийн иргэдийг зонхилон тохиолдох халдварт, халдварт бус өвчлөлийн эрт илрүүлэг үзлэгт жил бүр хамруулах. | 2021-2024 | ЭМДС 0.766 | Зорилтот бүлгийн иргэдийн үзлэгт хамрагдалтын хувь | 2019 | 45 | 47 | Урьдчилан сэргийлэх багцын үзлэг /18-34, 35-45, 46-64, 65-аас дээш/ шинжилгээг 3206 иргэнийг хамруулж зорилт бүлгийн иргэдийн үзлэгт хамрагдалт 48 хувь байна. Нийт 766.000 төг санхүүжүүлт хийгдсэн. | 100 |
| | | | | Урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан хүн амын эзлэх хувь | 2019 | 33 | 33.3 | Аймгийн нийт хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах хүрээнд нийт 67048 иргэний хамруулж үзлэгт хамрагдалтын хувь 45 байна. | |
| 2.1.1.4 | Арга хэмжээ: Эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл хяналтыг сайжруулж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлж, эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааны зохицуулалтыг сумдын ИТХ-аар шийдвэрлүүлэх. | 2021-2024 | - | Зайлшгүй болон амин чухал эмийн хангалтын хувь | 2019 | 86.5 | 87.2 | Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/ 625 дугаар тушаалаар батлагдсан эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээний төрлийн дагуу зайлшгүй шаарлагатай эм болон эмийн чанар аюулгүй байдлыг хanган тасралтгүй, хүртээмжтэй хангаж байна. Эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэн төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын зайлшгүй болон амин чухал эмийн хангалт 88,5 хувьтай байна. | 100 |
| | | 2021-2024 | Улсын төсөв 8.2 | Төлбөрийг нь төр хариуцдаг эмийн гүйцэтгэлийн хувь | 2019 | 82 | 83 | Төлбөрийг нь төр хариуцдаг эмийн хангалтаар 9 төрлийн оноштой, 935 хүнд, 32 нэр төрлийн 19.003.417 төгрөгний эмийг олгосон. Гүйцэтгэл 87 хувь байна. | |
| | | 2021 | - | Эрх зүйн орчин шийдвэрлэгдсэн эмийн эргэлтийн сангийн тоо | 2019 | 0 | 15 | 15 эмийн эргэлтийн сангийн өнөөгийн статусыг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид болон Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэлээ. | |
| 2.1.2 | Зорилт Эхийн эндэгдэлгүй ажиллаж, хүүхдийн тусламж үйлчилгээний чанарыг | 2021-2024 | - | Эхийн эндэгдэлийн түвшин | 2019 | 0 | 0 | Нэгдсэн эмнэлгийн ЭЗӨГ-ын жирэмсний хяналтыг сайжруулах зорилгоор өндөр өртөмтгий | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулан тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 2019 онд 10.8 байсныг 2024 онд 9 хүргэж бууруулна. | | | | | | | жирэмсэн эмэгтэйчүүдийг хянаж нийт 782 жирэмсэн эмэгтэйг нарийн мэргэжлийн эмчийн хяналтанд хянаж төрүүлсэн байна. Жирэмсний эрт хяналтын хувь 89,3 хувьтай эхийн эндэгдэлгүй ажиллаж байна. Эхийн жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үеийн ноцтой хүндрэлийн тохиолдол бүртгэгдээгүй байна. | |
| | | 2021-2024 | | 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/ промиль | 2019 | 10.8 | 10.6 | Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл /1000 амьд төрөлтөд/ 9,0 промиль байна. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 3 тохиолдолд эмч нарын эмнэлзүйн хурлыг хийж, хүүхдийн өвчлөл эндэгдлийн шалтгааныг тодруулан Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд хүргүүлсэн. | |
| | | 2021-2024 | | Сурфактант эмчилгээ хийсэн тоо | 2019 | 4 | 2 | Эхийн жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үеийн ноцтой хүндрэлийн тохиолдол бүртгэгдээгүй байна. Хүүхдийн рентген оношлогоо 1089, ЭХО шинжилгээ 2, нүдний уг 8 түнхний ЭХО 230, зүрхний цахилгаан бичлэг 7 хүүхдэд тус тус хийгдэж эмнэлзүйн оношлогоо эмчилгээ хийлээ.<br>Ургийн гажиг илрүүлэх дүрс оношлогооны шинжилгээг давхардсан тоогоор 294 жирэмсэн эхчүүдэд 13, 20, 32 долоо хоногтойд хийсэн ба 4 гажгийг эрт илрүүлсэн байна. 2 дутуу нярайд сурфактант эмчилгээг амжилттай хийсэн. | |
| 2.1.2.1 | Арга хэмжээ: Нэгдсэн эмнэлэг болон сумдын | 2021-2024 | - | Эхчүүдийн амрах байраар | 2019 | 194 | 253 | Нэгдсэн эмнэлэг болон сумдын эрүүл мэндийн төвүүдийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | эмнэлгүүдийн эхчүүдийн амрах байрны орчин нөхцөлийг сайжруулах | | | амарсан эхийн тоо | | | | эхчүүдийн амрах байрын орчин нөхцлийг сайжруулснаар нийт 262 эх амарсан байна. | |
| 2.1.2.3 | Арга хэмжээ: Сумдад 0-5 насны архаг хоол тэжээлийн дутагдалтай хүүхдийг эрүүлжүүлэх сувилал ажиллуулах. | 2021-2024 | - | Сувиллын тоо | 2019 | 0 | 4 | 5 сумын эрүүл мэндийн төвд сувиллын ор ажиллуулж 0-5 насны архаг хоол тэжээлийн дутагдалтай 20 хүүхдийг сувилалд хамруулж жингийн дутагдлыг арилгаж эрүүлжүүлсэн. | 100 |
| 2.1.3 | Зорилт Эмнэлгийн тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, хэрэглэгчийн үнэлгээний эерэг үзүүлэлт 2019 онд 91.5 хувь байсныг 2024 онд 93.6 хувьд хүргэнэ. | 2021-2024 | УТ 4287.7 | Хэрэглэгчийн үнэлгээний хувь | 2019 | 91.5 | 92.1 | Эрүүл мэндийн яамнаас баталсан журам, аргачлалын дагуу нийт 1078 үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэхэд эерэг үзүүлэлт 0,2 хувиар өсөж, муу үзүүлэлт 0,02 хувиар буурсан байна. Хэрэглэгчийн үнэлгээний үзүүлэлт 93 хувьтай байна. | 100 |
| 2.1.3.1 | Арга хэмжээ: Нэгдсэн эмнэлгийг компьютер томографи, сумдыг мобайль технологоор хангана. | 2021-2024 | - | Мобайль технологоор хангагдсан сумын тоо | 2019 | 4 | 8 | Хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй. | 0 |
| 2.1.3.2 | Арга хэмжээ: Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдийн эрүүл мэндийн даатгалаар үзүүлэх тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлж, гүйцэтгэлд суурилсан санхүүжилтыг хэрэгжүүлэх. | 2021-2024 | ЭМДС 4.2 | Нэр төрлийн тоо | 2019 | 11 | 13 | Нэгдсэн эмнэлэг нь гүйцэтгэлээр санхүүжих тогтолцоонд 3 сараас эхлэн шилжиж 13 нэр төрлөөр эмчилгээ үйлчилгээг үзүүлж байна. | 100 |
| | | 2021-2024 | | Санхүүжилтын гүйцэтгэлийн хувь | 2019 | 84.0 | 86.5 | Санхүүжилтийн гүйцэтгэлийн хувь 91хувь байна. | |
| 2.1.3.3 | Арга хэмжээ: Хот хоорондын зам дагуух сумдын болон алслагдсан бүс нутгийн эмнэлгүүдэд яаралтай тусламжийн цэг байгуулах. | 2021-2024 | УТ 1.2 | Яаралтай тусламжийн цэгийн тоо | 2020 | 1 | 2 | Дэлгэрцогт, Хулд, Луус сумдад яаралтай тусламжийн цэгийг байгуулснаар нийт осол гэмтлийн тусламж үйлчилгээ 43-ийг үзүүлсэн. Үүнээс: авто осол 15, мотоциклоос унасан 5, бусдад зодуулсан 6, хугарал бэртэл 3 ,нохойд уруулсан 3, түлэгдэл 8, хурц зүйлийн нөлөөтэй гэмтэл 3 /хутгалагдсан 3/ тусламж | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үйлчилгээ үзүүлсэн байна. | |
| 2.1.3.4 | Арга хэмжээ: Эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн автомашины парк шинэчлэлт хийж, яаралтай тусламжийн зөөврийн тоног, төхөөрөмжөөр тоноглох | 2021-2024 | УТ 163.8 | Яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 2019 | 45 | 46 | ДЭМБ байгууллага, Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар яаралтай тусламжийн тоног төхөөрөмж хангах зорилгоор 163,8 сая төгрөгийн хүчилтөрөгч өтгөрүүлэгч -14 ш, пульсоксиметр 18 ш, халуун хэмжигч-6 ш, амбу-2 ш, Монитор -4ш , Автомакс-9 ширхэг нийт 10 төрлийн тоног төхөөрөмжөөр хангалаа. Яаралтай тусламжийн тоног төхөөрөмжийн хангалт 55,3 хувьтай байна. | 100 |
| | | 2021-2024 | - | Тоноглосон тоо | 2019 | 1 | 2 | Нэгдсэн эмнэлэгийн түргэн тусламжийн автомашиныг хүчилтөрөгч өтгөрүүлэгч, амбу, хэл дарагч, ларингоскопи, гэмтлийн бэхэлгээ, зөөврийн зүрхний цахилгаан бичлэгийн аппаратаар тоноглосон. | |
| | | 2021-2024 | УТ 31.0 | Машины хангалтын хувь | 2019 | 90 | 92 | Эрүүл мэндийн яамны 33,5 сая хөрөнгө оруулалтаар Дэрэн сумын эрүүл мэндийн төвд автомашин олголоо. Автомашины хангалт 92,0 хувьтай боллоо. | |
| 2.1.3.5 | Арга хэмжээ: Хоёрдогч шатлалын нарийн мэргэжлийн оношилгоо, эмчилгээ, зөвлөгөөг анхан шатны эмнэлгүүдэд алсын зайнаас авах цахим харилцааны нөхцөлийг бүрдүүлэн компьютерээр хангах. | 2021-2024 | УТ 26.6 | 2 догч шатлалын эмнэлэгээс онлайнаар зөвлөгөө авсан тоо | 2019 | 0 | 10 | Эрүүл мэндийн төвүүдээс хоёрдогч шатлалын эмнэлэг буюу аймгийн нэгдсэн эмнэлгээс онлайнаар 15 тохиолдол дээр зөвлөгөө авсан байна. | 100 |
| | | 2021-2024 | УТ 76.5 | Компьютерийн тоо | 2019 | 15 | 31 | Анхан шатны эрүүл мэндийн байгууллага бүрийг нийт 66 компьютерээр хангалаа. | |
| 2.1.3.1 | Дэд зорилт Эмнэлэгүүдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулж, тоног төхөөрөмжийн хангалт 2019 онд 85.0 байсныг 2024 онд | 2021-2024 | УТ Хандив тусламж 3,967.2 | Нэн шаардлагатай тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 2019 | 85.0 | 85.6 | 29 нэр төрлийн 4.060.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангагдлаа. Тоног төхөрөөмжийн хангалт 87 хувьтай байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 86.7 хувьд хүргэнэ. | | | | | | | | |
| 2.1.3.1.1 | Арга хэмжээ: Нэгдсэн эмнэлэг болон Өндөршил, Дэрэн, Цагаандэлгэр сумдын эрүүл мэндийн төвүүдийн барилгыг шинээр барих. | 2021-2024 | УТ 3,200.0 | Шинээр барьсан эмнэлгийн барилгын тоо | 2019 | 11 | 12 | Сайнцагаан сумын 100 ортой Нэгдсэн эмнэлгийн барилгын угсралтын ажлыг 2019 онд “Тэнгэрийн тэмдэг” ХХК 8,752,9 сая төгрөгийн санхжүүлтэйгээр гэрээ байгуулж 2021 онд үлдэгдэл 5 тэрбум төгрөгийн санхүүжилт авч ажлын явц 85 хувьтай байна. Ингэснээр 12 эмнэлэг эрүүл мэндийн төвийн барилга шинэчлэгдэж байна. | 80 |
| 2.1.3.1.3 | Арга хэмжээ: Нэгдсэн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төв, сум дундын эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийг оношилгоо, эмчилгээний тоног, төхөөрөмжөөр хангах. | 2021-2024 | 20.8 хандив тусламж | Сум өрхийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 2019 | 78.5 | 78.7 | Сумдын эрүүл мэндийн төвүүдэд 20,8 сая төгрөгийн Цогцос хадгалах хөргөгч, эмгэг судлалын ширээ, өвчтөний ор, Хүчилтөрөгчийн аппарат, Пульс оксиметер, тарианы тэргэнцэр зэрэг 10 нэр төрлийн тоног төхөөрөмжийг хандив тусламжаар олголоо. Сумдын эрүүл мэндийн төвийн тоног төхөрөөмжийн хангалтын хувь 85,6 байна. | 100 |
| | | 2021-2024 | - | Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 2019 | 91.2 | 92.0 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт Глобал сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн хүрээнд 187,1 сая төгрөгийн өртөг бүхий зөөврийн дижитал рентген аппарат, ДЭМБ болон бусад хандивлагч байгууллагын тусламжтайгаар 534,9 сая төгрөгийн Зөөврийн ЭХО, хяналтын монитор зэрэг 8 төрлийн тоног төхөөрөмж, Эрүүл мэндийн яамны 27,9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар эх, нярай, эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай багаж тоног төхөөрөмж бүхий хяналтын | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | монитор, нярайн дулаацуулах ширээ, нярайн шарлалт эмчлэх аппарат, төрөхийн ор, кесар хагалгааны багцыг тус тус олголоо. Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтын хувь 92,8 байна. | |
| 2.1.3.1.4 | Арга хэмжээ: Нүхэн жорлонтой эрүүл мэндийн байгууллагуудын дунд сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болох хөдөлгөөнийг үе шаттай өрнүүлэх. | 2021-2024 | УТ 0.6 | Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай ЭМБ-ын эзлэх хувь | 2019 | 52.4 | 60.2 | Нүхэн жорлонтой эрүүл мэндийн байгууллагуудын дунд сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болох болзолт 3 сарын аяныг зарласан. Сайжруулсан ариун цэврийн байгууламжтай эрүүл мэндийн байгууллага 11 болсон нь 73.3 хувийг эзэлж байна. | 100 |
| 2.1.4 | Зорилт: Хүний нөөцийн хангалтыг 2019 онд 96.7 хувь байсныг 2024 он гэхэд 97.5 хувьд хүргэнэ. | 2021-2024 | УТ 19.2 | Хүний нөөцийн хангалтын хувь | 2019 | 96.7 | 96.8 | Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалт 96.8 хувьтай байна. | 100 |
| 2.1.4.1 | Арга хэмжээ: Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэх замаар орон сууцаар хангах | 2021-2024 | УТ 12.0 | Орон сууцаар хангагдсан албан хаагчдын эзлэх хувь | 2019 | 41.8 | 42 | Дэлгэрхангай, Дэрэн, Дэлгэрцогт, Өндөршил сумдад шинээр ирсэн эмч нарын орон байрны асуудлыг шийдвэрлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 5 эмч, эмнэлгийн мэргэжилтэн орон байрны нөхцлөө сайжруулсан байна. Орон сууцаар хангагдсан албан хаагчийн эзлэх хувь 42 байна. | 100 |
| 2.1.4.2 | Арга хэмжээ: Эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг мэргэшүүлэн бэлтгэх. | 2021-2024 | - | Нарийн мэргэжлийн эмчийн хангалтын хувь | 2019 | 94 | 94.6 | Нарийн мэргэжлийн эмчийн хангалтын хувь 94.8 байна. | 100 |
| | | 2021-2024 | УТ 7.2 | мэргэшүүлсэн эмнэлгийн тусгай мэргэжилтний тоо | 2019 | 8 | 16 | Анатомын эмгэг судлал, арьс судлал, дүрс оношлогоо судлал, хавдар судлал, эх барих эмэгтэйчүүд, уламжлалт анагаах ухаан судлалаар нарийн | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | мэргэжлийн эмч бэлтгэхээр Эрүүл мэндийн хөгжлийн төвд захиалгыг хүргүүлснээр арьс судлал, хавдар судлал, биостатистикийн эмчийг бэлтгэж байна. Нэгдсэн эмнэлэг, Луус, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Адаацаг сумын эрүүл мэндийн төвүүдэд ариутгагч, дархлаажуулалт, мэдрэл, мэс засал, хүүхэд серилоги лаборант, чиглэлээр эмнэлгийн тусгай 9 мэргэжилтэнг мэргэшүүлэн бэлтгэсэн. Нийт 17 сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтэн, их эмч 9-ийг бэлтгэлээ. | |
| 2.1.4.2.1 | Арга хэмжээ: Анагаахын их сургуулиудтай хамтран ажиллаж орон нутагт нэн шаардлагатай сувилагч мэргэжилтний хангалтыг нэмэгдүүлэх. | 2021-2024 | - | Сувилагч мэргэжилтний хангалтын хувь | 2019 | 83.3 | 84.6 | Глобал удирдагч дээд сургуультай хамтран 2021 оны хичээлийн жилд 25 сувилагч гэрээ байгуулан суралцаж байна.Сувилагч мэргэжилтний хангалт 94,0 хувьтай байна. | 100 |
| 2.1.4.2.2 | Арга хэмжээ: “Ахмадын ордон”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн төв”-д ахмад настнууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлэх мэргэшлийн хүний нөөцийг сурган бэлтгэх. | 2021-2024 | - | Сэргээн засах тусламж үзүүлэх мэргэшсэн хүний нөөцийн тоо | 2019 | 0 | 1 | Дорноговь аймгийн Анагаах ухааны сургуульд сэргээн засах тусламж үйлчилгээний чиглэлээр 11 сувилагчийг мэргэшүүлэн бэлтгэсэн. | 100 |
| | **2.2. Биеийн тамир, спорт** | | | | | | | | |
| **2.2** | Зорилго: Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилд хамрагдагчдыг 1835-аар нэмэгдүүлж, А, В үнэлгээтэй иргэд 2019 онд 21.9 хувьтай | 2021-2024 | - | Сорилд нийт хамрагдагчдын тоо | 2019 | 3365 | 3823 | Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг 2021 оны 11 дүгээр сарын 01-ны өдрөөс 12 дугаар сарын 06-ны өдрүүдэд зохион байгуулсан. Сорилд нийт 14 сум, 35 байгууллагын 9500 иргэнийг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байсныг 2024 онд 33.9 хувьд хүргэнэ. | | | | | | | хамруулж, үнэлгээ хийсэн. Сорилд хамрагдсан нийт иргэдээс А үнэлгээтэй 1300, В үнэлгээтэй 1165 иргэн байна. | |
| | | 2021-2024 | | Сорилд хамрагдагчдын А, В үнэлгээтэй иргэдийн эзлэх хувь | 2019 | 21.9 | | Сорилд хамрагдагчдын А, В үнэлгээтэй иргэдийн эзлэх хувь 25 хувьтай байна. | |
| 2.2.1 | Зорилт: Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчид 2019 онд 25193 байсныг 2024 онд 28105-д хүргэнэ. | 2021-2024 | Засаг даргын нөөц 1.2 ЭМГ-0.5 УТ- 4.0 | Нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчдийн тоо | 2019 | 25193 | 25921 | Нийтийн биеийн тамир, спортоор тогтмол хичээллэгч 26058 иргэн байгаагийн ихэнх хувь нь орон нутгийнхаа онцлог буюу байршлаасаа шалтгаалан үндэсний уламжлалт морь, бөх, сур, шагайн спорт болон дугуй унах, гүйх, алхах зэрэг төрлүүдээр хичээллэж байна. | 100 |
| 2.2.1.1 | Арга хэмжээ: Иргэдийг эрүүл амьдралын идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллүүлэх | 2021-2024 | УТ-2.0 | Идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэгчдийн тоо | 2020 | 8125 | 9180 | Аймгийн хэмжээнд нийт 10645 иргэн бүжиг, аэробик, спинэнг, фитнесст явж, идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэн, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлж байна. | 100 |
| 2.2.1.1.1 | Дэд арга хэмжээ: Спортын холбоод болон спорт хамтлагуудын үйл ажиллагааг өргөжүүлэх | 2021-2024 | Үндэсний бөхийн холбоо 5.0 МСУХолбоо 8.0 Дугуйн холбоо 0.5 УТ-1.0 Шагайн холбоо 3.0 | Спортын холбоодтой хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | 2020 | 12 | 13 | Үндэсний сур, шагай, морь, бөхийн холбоо болон Дугуйн холбоо, Дартсын холбоо, Буудлагын холбоо, Таеквондогийн клуб, Бүжгийн клуб зэрэг аймагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа спортын 12 холбооны удирдлага, гишүүд, тамирчидтай хамтран 18 удаагийн үйл ажиллагааг хамтран зохион байгуулсан. | 100 |
| | | 2021- | ОНТ 1.1 | Спорт | 2020 | 26 | 29 | “Эрүүл мэндийн цахим гүйлт”, | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2024 | | хамтлагуудтай хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны тоо | | | | “Дасгал хөдөлгөөн хийцгээе”, “Идэвхитэй хөдөлгөөнийг дэмжих” сарын аян, “Цагаан таягтны өдөр”, “Эртэч Мандалговьчууд” өдөрлөг, “Цахим гүйлт”, “Үндэстнээрээ нэг баг болон гүйцгээе”, “Гимнастрада” зэрэг арга хэмжээний хүрээнд 13 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдийн спорт хамтлагуудтай хамтран, нийт 36 төрлийн арга хэмжээ зохион байгуулсан. | |
| 2.2.1.1.2 | Дэд арга хэмжээ: Монгол улсын гавьяат дасгалжуулагч А.Доржсүрэнгийн нэрэмжит өсвөрийн волейболчдын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах | 2021-2023 | - | УАШ-х тэмцээнд оролцсон багийн тоо | 2018 | 70 | 72 | Улс орны хэмжээнд коронавируст /Covid-19/ цар тахал дэгдсэнтэй холбогдуулан Биеийн тамир, спортын улсын хорооноос батлан гаргадаг уралдаан, тэмцээний хуваарьт 2022 онд зохион байгуулахаар орсон.Орон нутгаас шалтгаалсан зүйл байхгүй. | 0 |
| 2.2.1.1.4 | Дэд арга хэмжээ: Монгол үндэсний уламжлалт спортыг өвлүүлэн уламжлуулах ажлыг зохион байгуулах | 2021-2024 | Аймгийн шагай холбоо 3,0<br>УТ 1.0 | Наран Хөгцтийн шагайн харвааны наадамд оролцсон багийн тоо | 2020 | 30 | 32 | Аймгийн аварга шалгаруулах Үндэсний уламжлалт шагайн харвааны наадмыг Дэрэн сумын Наран хөгцтийн тойромд 2021 оны 08 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулсан. Тус наадмыг багийн болон хувийн цуваа харваа гэсэн 2 төрлөөр явуулж, нийт 13 сумын 32 багийн 186 харваачид цэц мэргэнээ сорин өрсөлдсөн. | 50 |
| | | 2021-2023 | - | Монголын хүүхдийн спортын наадамд оролцсон спортын төрлийн тоо | 2019 | 9 | 12 | Коронавируст цар тахал дэгдсэнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 08 дугаар сарын 31- ний өдрийн 268 дугаар тогтоолоор<br>Монголын хүүхдийн спортын VII наадмыг 2023 онд зохион | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | байгуулахаар хойшлуулсан. | |
| 2.2.1.1 .5 | Дэд арга хэмжээ: Сагсан бөмбөгийн 3х3 спортын төрлийг орон нутагт дэмжин хөгжүүлэх | 2021-2024 | - | 3х3 спортын төрлөөр хичээллэгчдийн тоо | 2020 | 4000 | 4300 | Аймгийн хэмжээнд 3х3 сагсан бөмбөгийн спорт сонирхогч 4800 гаруй хүүхэд, залуучууд хичээллэж байна. | 100 |
| | | 2021-2024 | - | 3х3 спортын багш, дасгалжуулагч, шүүгчээр бэлтгэгдсэн хүний тоо | 2020 | 0 | 20 | Сургуулийн биеийн тамирын багш болон клубын дасгалжуулагч зэрэг нийт 22 багш дасгалжуулагчид сургалт зохион байгуулж, 3х3 спортын шүүгчээр бэлтгэсэн. | |
| 2.2.1.2 | Арга хэмжээ: Аймгийн Цэнгэлдэх хүрээлэнг ашиглалтад оруулан, спортын талбайг байгуулах | 2021 | УТ-1,5 | Барилга байгууламжийн гүйцэтгэлийн хувь | 2020 | 73 | 100 | “Зуут констракшин” ХХК нь 2021 оны 04 дүгээр сараас барилгын ажлыг эхлүүлэн, үзэгчдийн суудал байршуулах, хашаажуулах, гүйлтийн зам, хөл бөмбөгийн талбайн цутгалтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын гүйцэтгэл 85 хувьтай байна. | 44.4 |
| 2.2.1.3 | Арга хэмжээ: Олон улсын стандартад нийцсэн усан бассейн бүхий спортын цогцолбор байгуулах | 2021 | УТ-230.0 | Спортын цогцолборын зураг төсвийг хийлгэсэн эсэх (тийм-1, үгүй-0) | 2020 | 0 | 1 | “Зэд прожект” ХХК-тай гэрээ байгуулан, усан бассейн бүхий спорт цогцолборын зураг, төсвийг гүйцэтгүүлэн, барилгын хөгжлийн төвөөр батлуулсан. | 100 |
| **2.3 . Боловсрол** | | | | | | | | | |
| **2.3.** | Зорилго: Сургалтын чанарын үнэлгээний дундаж 2019 онд 39.1 хувь байсныг 2024 онд 47 хувьд хүргэнэ. | 2021-2024 | 1.5 ОНТ | Боловсролын чанарын үнэлгээний хувь | 2019 | 39.1 | 41 | Боловсролын үнэлгээний төвтэй хамтран аймгийн 12 сургуулийн 2-12 дугаар ангид оношлох үнэлгээ шалгалт авах ажлыг 7890 сурагчдыг хамруулан зохион байгуулж, шалгалтын материалыг хүргүүлсэн 12 сарын байдлаар дүн мэдээ эцэслэж гарна. | - |
| **2.3.1** | Зорилт: Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 2020 онд 72.5 хувь байсныг 2024 онд 76 хувьд | 2021-2024 | - | СӨБ-ын хамран сургалтын хувь | 2020 | 72.5 | 73 | 2021-2022 оны хичээлийн жилд 4 настай аймгийн нийт 1062 хүүхдийн 65.3 хувь, 5 настай 1071 хүүхдийн 83.7 хувь нь цэцэрлэгт | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүргэнэ. | | | | | | | хамрагдаж, СӨБ-ын хамран сургалтын дундаж хувь 74.5 байна. | |
| 2.3.1.1 | Арга хэмжээ: Сайнцагаан, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, Адаацаг, Хулд, Цагаандэлгэр суманд шинээр цэцэрлэгийн барилга барих | 2021-2024 | - | Ашиглалтад шинээр орсон цэцэрлэгийн тоо | 2020 | 2 | 3 | Сайнцагаан сумын 2 дугаар цэцэрлэг, Дэлгэрцогт, Эрдэнэдалай сумдын шинэ цэцэрлэгийн барилгын техник эдийн засгийн үзүүлэлт болон бусад анхан шатны бичиг баримт материалыг 100% бүрдүүлэн холбогдох дээд газарт хүргүүлсэн. Дэлгэрцогт сумын шинэ цэцэрлэгийн барилгын зураг төсвийг “ЧУЛУУТИЙН БАГШ” ХХК-д хийлгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. 2021 оны 12 дугаар сард цэцэрлэгүүдийн зураг төсөв бэлэн болно. Энэ онд ашиглалтанд орсон цэцэрлэг байхгүй болно. | 0 |
| 2.3.1.2 | Арга хэмжээ: 1-2 настай хүүхдийг яслийн бүлэгт, 2-3 настай хүүхдийг хүүхэд харах үйлчилгээнд хамруулах | 2021-2024 | - | Хүүхэд харах үйлчилгээний тоо | 2020 | 0 | 1 | Хүүхэд харах үйлчилгээ нь Хөдөлмөр Нийгмийн Хамгааллын яамны харьяанд шилжихээр эрх зүйн зохицуулалт хийгдсэн тул үйл ажиллагаа явагдаагүй болно. | 0 |
| 2.3.1.3 | Арга хэмжээ: Цэцэрлэгийн бүлгийн багш нарыг хөгжим тоглох ур чадварт сургана. | 2021-2024 | ОНТ 4.2 | хөгжим тоглож сурсан бүлгийн багшийн эзлэх хувь | 2020 | 0 | 30 | Энэ 2021-2022 оны хичээлийн жилд 22 цэцэрлэгийн 100 бүлгийн багш нар хөгжим тоглож сурах сургалтыг цэцэрлэг дээрээ зохион байгуулан ажиллаж, үүнээс 87 бүлгийн багш буюу 87 хувь нь хөгжим тоглох сургалтад хамрагдан хүрэх түвшнээс 57 хувиар өссөн сайн үзүүлэлттэй байна. | 100 |
| 2.3.1.4 | Арга хэмжээ: СӨБ-ын урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2021-2024 | УТ 2268,7 | Хөгжим болон биеийн тамирын хичээлийн | 2020 | 2 | 7 | Дэлгэрцогт, Өлзийт, Эрдэнэдалай сумын хүүхдийн цэцэрлэгт орчин үеийн шаардлага хангасан 2253.0 сая төгрөгний иж бүрэн техник, | 80 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | кабинетын тоо | | | | тоглоом хэрэгсэл бүхий биеийн тамирын кабинет, “Эх соёл, эх үндэс” төслийн хүрээнд Сайнцагаан сумын 2-р цэцэрлэгийн дуу хөгжмийн кабинетад 15,7 сая төгрөгийн санхүүжилтээр хөгжмийн зэмсэг, ухаалаг самбар олгосон. Ингэснээр аймгийн хэмжээнд нийт 6 кабинетыг тоног төхөөрөмжөөр ханган хүүхэд хөгжих орчин сайжирлаа. | |
| 2.3.2 | Зорилт: ЕБС-ийн бага, суурь боловсролын хамран сургалт 2020 онд 91.6 хувь байсныг 2024 онд 96.5 хувьд хүргэнэ. | 2021-2024 | - | Бага, суурь боловсролын хамран сургалтын хувь | 2020 | 91.6 | 93 | Бага боловсролын хамран сургалт 99.4 хувь, суурь боловсролын хамран сургалт 99.5 хувь, нэгдсэн дундаж 99.4 хувьтай байна. | 100 |
| 2.3.2.1 | Арга хэмжээ: Сайнцагаан, Сайхан-Овоо, Эрдэнэдалай, Дэлгэрцогт, сумдад шинээр сургуулийн барилга барих | 2021-2024 | 5,000.0 УТ | Ашиглалтад шинээр орсон сургуулийн тоо | 2020 | 0 | 1 | Сайхан-Овоо сумын сургуулийн барилга 3.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй бөгөөд 2021 онд 1,5 тэрбум төгрөг хөрөнгө оруулалт хийгдэж, барилгын ажил 30 хувийн гүйцэтгэлтэй, Говийн-Ирээдүй цогцолбор сургуулийн барилгын ажлын суурийн хэсгийн ажил хийгдсэн. | 0 |
| 2.3.2.2 | Арга хэмжээ: Сайнцагаан, Адаацаг, Говь-Угтаал, Дэлгэрхангай, Эрдэнэдалай сумдад шинээр дотуур байрын барилга барих | 2021-2024 | УТ 1,000.0 | Ашиглалтад шинээр орсон дотуур байрын тоо | 2020 | 1 | 2 | Гурвансайхан сумын дотуур байрны барилгын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй баригдсан. | 100 |
| 2.3.2.4.1 | Дэд арга хэмжээ: Оюутан суралцагчтай гэрээ хийх замаар нэн шаардлагатай мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлэх | 2021-2024 | ОНТ 6.0 | гэрээ байгуулсан оюутны тоо | 2020 | 0 | 2 | Өлзийт сумын Засаг дарга Ерөнхий боловсролын сургуульд нэн шаардлагатай байгаа бага анги болон химийн багшаар төгсөх 2 төгсөгчтэй гэрээ байгуулан мэргэжлийн багшаар хангасан. | 100 |
| 2.3.2.5 | Арга хэмжээ: Улс, аймгийн туршлагатай багш нарыг түшиглэн сургалт, чансаа | 2021-2024 | ОНТ 30.0 | 10 судлагдахууны аймгийн | 2020 | 498.4 | 500 | ЭЕШ-ын 10 судлагдахуунаар 14 хоногт 1 удаа сорил зохион байгуулах хуваарь гарган 8-н | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тогтоох сорилуудыг зохион байгуулж, элсэлтийн ерөнхий шалгалтын дундаж оноог ахиулах | | | дундаж оноо | | | | удаагийн сорилыг зохион байгуулж дүн мэдээг нэгтгэж сургууль, төгсөгч, эцэг эхчүүдийн нэгдсэн онлайн уулзалтаар танилцуулж анхаарах асуудлуудаар мэдээлэл хүргэсэн. 2021 оны ЭЕШ-ын 10 хичээлийн дундаж оноо-523, өмнөх оныхоос 3-129 оноогоны өсөлттэй, үүнээс 6 хичээл улсын дунджаас өссөн үзүүлэлттэй байна. | |
| 2.3.2.5 .1 | Дэд арга хэмжээ: Бага, суурь боловсролын багш нарыг 100 хувь зөвлөх багийн үйлчилгээнд хамруулах | 2021-2024 | - | бага боловсролын багш нарын хамрагдалтын хувь | 2020 | 50 | 70 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй бага ангийн 45 багш, 6 удирдах ажилтан үндэсний сургалтад, 150 багш буюу 100 хувь орон нутгийн сургалтад бүрэн хамрагдаад байна. | 100 |
| | | 2021-2024 | - | суурь боловсролын багш нарын хамрагдалтын хувь | 2020 | 50 | 70 | Аймгийн хэмжээнд 2020-2021 оны хичээлийн жилд 17 судлагдахуунаар мэргэжлийн бүлэг байгуулан ажиллаж, суурь боловсролын багш нарыг 100 хувь сард 2-оос доошгүй удаа мэргэжлийн бүлгийн уулзалт, хэлэлцүүлэгт хамруулж, 2021-2022 оны хичээлийн жилд сурлагын хоцрогдол арилгах агуулгын төлөвлөлт, арга зүйн талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав. Мөн “Сайн хичээл 2021” арга хэмжээний хүрээнд сургууль бүрээс ирүүлсэн 214 багш нарын 214 хичээлд зөвлөх багаас үнэлгээ дүгнэлт, зөвлөгөө чиглэл өгч, шалгуур хангасан хичээлийг цахим сайтад байршуулан олон нийтэд түгээн дэлгэрүүлэв. | |
| 2.3.2.6 | Арга хэмжээ: Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлэх | 2021-2024 | 10.0 ОНТ | Төлөвлөгөөний хэрэгжилтийн | 2020 | 0 | 50 | Чадварлаг багш арга хэмжээний төлөвлөгөөнд туссан 4 чиглэлийн ажил 100 хувь хэрэгжив. Үүнд | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хувь | | | | “Сайн хичээл аймгийн зөвлөгөөн”, ”Эрдэм шинжилгээний хурал”, ”Аймгийн бүтээлийн сан баяжуулалт”, “Тэргүүлэх багш нарын арга туршлагыг түгээн дэлгэрүүлэлт” гэсэн ажлууд бүрэн хэрэгжиж, төлөвлөгөөний гүйцэтгэл 80 хувьтай байна | |
| 2.3.2.6 .1 | Дэд арга хэмжээ: СӨБ, ЕБС-ийн багш нарыг дотоодод туршлага судлуулах | 2021-2024 | - | Тухайн жилд туршлага судалсан багшийн тоо | 2020 | 27 | 60 | 2021 онд Дэлгэрхангай суманд СӨБ-ын баруун бүсийн багш нарын туршлага солилцох зөвлөгөөн зохион байгуулсан. Нийт 8 цэцэрлэгийн 69 багш, арга зүйч, эрхлэгч нар хамрагдсан. Багш нарын арга туршлагыг цахимаар түгээх арга хэмжээний хүрээнд 58 багшийн цахим хичээлийг www.dundgovi.gov.mn сайт дээр байршуулан 1339 хүний хандалт авсан. | 100 |
| 2.3.2.6 .2 | Дэд арга хэмжээ: ЕБС-ийн урлаг, биеийн тамирын хичээлд шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | 2021-2024 | Төсөл 118.0 | Хөгжмийн хичээлийн кабинетын тоо | 2020 | 2 | 6 | “Эх соёл эх үндэс” төслийн хүрээнд Сайнцагаан сумын 3-р сургуулийн 5 танхимуудад 118.0 сая төгрөгийн кабинетын тоног төхөөрөмж бүхий хөрөнгө оруулалт хийгдсэн. Нийт кабинетийн тоо 6 байна. | 100 |
| | | 2021-2024 | | Биеийн тамирын хичээлийн кабинетын тоо | 2020 | 2 | 6 | 4 сургуулийн биеийн тамирын хичээлийн кабинетыг тоног төхөөрөмжөөр хангагдсанаар нийт 6 кабинеттай болсон. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.2.7 | Арга хэмжээ: Аймгийн Насан туршийн төв, сумдын насан туршийн нэгжүүдээр дамжуулан 9-12-р ангийн суралцагчид болон иргэд, эцэг эхчүүдэд амьдрах ухаан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, насан туршдаа суралцахуйн чиглэлээр үе шаттай сургалтуудыг зохион байгуулах | 2021-2024 | - | Сургалтад хамрагдсан суралцагч, иргэд, эцэг эхийн хувь | 2019 | 32 | 34 | Энэ хичээлийн жилд аймгийн МСҮТ, Өмнөговь аймгийн НТБТ болон төрийн өмчит 6 их дээд сургуулийн удирдлагууд, сургагч багш нартай хамтран эцэг эх, 9-12-р ангийн нийт 1815 суралцагч, 360 иргэд, эцэг эхчүүд буюу нийт 40.2 хувийг цахим сургалтад 3 удаа хамруулж, амьдрах ухаан, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, уул уурхайн чиглэлээр суралцагчдад мэдээлэл ойлголтыг өгч ажиллав. | 100 |
| 2.3.2.8 | Арга хэмжээ: Сургууль бүрт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах танхим байгуулах | 2021-2024 | 25.0 УТ | Танхимын тоо | 2020 | 0 | 5 | БШУЯ-аас Мандал, ГИЦС-д сургуульд хөгжлийн 2 танхим байгуулж, Сайхан-Овоо сумын сургуулийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сургах загвар орчин бүрдүүлэх төсөлд хамруулсан бөгөөд нийт ашиглалтад оруулсан танхимын тоо 3 байна. | 60 |
| 2.3.2.9 | Арга хэмжээ: Сургууль бүрт байгалийн ухааны хичээлийн кабинет байгуулах | 2021-2024 | 4.5 УТ | Байгуулсан кабинетын тоо | 2020 | 3 | 4 | Азийн хөгжлийн банкны санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх” төслийн хүрээнд аймгийн Сайнцагаан сумын Мандал, Хүмүүнлэг сургуулиудын химийн кабинетыг түшиглэн 4570.0 мянган төгрөгний химийн туршилт явуулах, бодис урвалжийг олгож байгалийн ухааны кабинетийг бий болголоо. Энэ нь суралцагчид туршилт явуулах боломжтой болсон. Ингэснээр аймгийн хэмжээнд байгалийн ухааны 5 кабинеттэй болоод байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.3.2.10 | Арга хэмжээ: Сургууль, дотуур байрыг 100% шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, дотор ОО-той болгох | 2021-2024 | 70.0 УТ | Дотор нойлтой сургуулийн тоо | 2020 | 12 | 13 | Адаацаг сумын сургуулийн дотор нойлын асуудал шийдэгдэн Дэлхийн зөн ОУБ, Мобикомын хамтарсан төслийн хүрээнд хийгдэж ашиглалтанд орлоо. Ингэснээр 13 сургууль дотор нойлтой боллоо. | 100 |
| | | 2021-2024 | 70.0 УТ | Дотор нойлтой дотуур байрны тоо | 2020 | 10 | 11 | Луус суманд шинэ дотуур байр баригдаж дотор ОО-ын асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Мөн 2021 онд багтаан Дэлгэрцогт, Эрдэнэдалай, Гурвансайхан сумын дотуур байр ашиглалтад орсноор дотор 00-ын асуудлыг бүрэн шийдвэрлэсэн. Аймгийн хэмжээнд дотор нойлтой дотуур байр тоо 11 боллоо. | |
| | | 2021-2024 | 10.0 УТ | Усанд орох нөхцөл бүрдсэн дотуур байрны тоо | 2020 | 11 | 13 | Луус суманд шинэ дотуур байр баригдаж дотор ОО, угаалтуур, усанд орох нөхцлийг бүрэн шийдвэрлэсэн. Мөн 2021 онд багтаан Дэлгэрцогт, Гурвансайхан сумын дотуур байр ашиглалтад орсноор усанд орох боломж бүрдсэн байна. Нийт 13 дотуур байр усанд орох нөхцөл бүрдээд байна. | |
| 2.3.2.11 | Арга хэмжээ: Цэцэрлэг, сургууль , дотуур байрны гадаад дотоод орчныг бүрэн камержуулах | 2021-2024 | 30.0 УТ | камертай сургууль, цэцэрлэг, дотуур байрны эзлэх хувь | 2020 | 50 | 60 | Цэцэрлэгийн хувьд камержилт 100 хувь, дотуур байрны камержилт 81.25 хувь, сургуулийн камержилт 89.5 хувь байна. Камерын хүчин чадлыг сайжруулах ажил 2021 онд Сайнцагааны 1, 3, 5 дугаар цэцэрлэгүүдэд хийгдсэн. Камертай сургууль, цэцэрлэг, дотуур байрны эзлэх хувь 90,2 байна. | 100 |
| 2.3.3 | Зорилт: МСҮТөвийг Магадлан итгэмжлэгдсэн Политехник коллеж болгож, | 2021-2024 | ОНТ 10.0 | Ажил эрхлэлтийн хувь | 2019 | 65 | 66.5 | 2021 оны байдлаар 2.5 жилийн ангийн нийт төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 55,8 хувь, 1 жилийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 2021-2024 | | хураан авсан ургацын хэмжээ(тн) | 2020 | 2.8 | 4.3 | 16,9 тн ургац хураан авсан. | |
| 3.3.1.9 | Арга хэмжээ: Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бизнес инкубацын үйлчилгээгээр бойжуулж, томруулах | 2021-2024 | - | Бойжуулсан бизнес эрхлэгчийн тоо | 2020 | 36 | 48 | 16 бизнес эрхлэгчийг зөвлөгөө мэдээллээр хангаж, цаашдын зээл авах үйл ажиллагаа өргөжүүлэхэд Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч гэсэн тодорхойлолт өгөн дэмжлэг үзүүлсэн. Нийт 52 иргэнг бойжуулан жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч болсон байна. | 100 |
| 3.3.1.10 | Арга хэмжээ: Өлзийт суманд ингэний фермерийн аж ахуйг байгуулж, сүүг үйлдвэр цехэд нийлүүлэн үнэлэмжийг нэмэгдүүлэх | 2021-2024 | - | Саалинд хамрагдах ингэний тоо | 2020 | 0 | 50 | 70 ингэ саан иргэдэд сүүг борлуулж байна. | 100 |
| | | 2021-2024 | - | Нийлүүлсэн сүүний хэмжээ (тн) | 2020 | 0 | 6.5 | 7,5 тн хоормог борлуулсан. | |
| 3.3.2. | Зорилт: Малын тоог чанарт шилжүүлж биотехнологийн ололтыг 2024 онд 2300 малд шинээр нэвтрүүлж малын хаврын амьдын жинг 3-5 хувиар нэмэгдүүлнэ | 2021-2024 | 3.0 УТ | шинээр хамрагдсан малын тоо | 2019 | 0 | 300 | Биотехнологийн аргаар сайнцагаан омгийн хуцыг сайжруулагчаар ашиглан 400 хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийгдлээ. | 100 |
| | | 2021-2024 | - | Малын амьдын жингийн өсөлт хувь | 2019 | 0 | 1 | Малын хавар, намрын амьдын өсөлт 3-5 хувиар нэмэгдсэн. | |
| 3.3.2.1 | Арга хэмжээ: Сайнцагаан омгийн хонинд зохиомол хээлтүүлэг хийх | 2021-2024 | 3.0 УТ | хээлтүүлсэн малын тоо | 2020 | 500 | 800 | Биотехнологийн аргаар сайнцагаан омгийн хуцыг сайжруулагчаар ашиглан энэ онд 400 эм хонинд зохиомол хээлтүүлгийн ажил хийгдсэн ба нийт 900 эм хонийг хээлтүүлээд байна. | 100 |
| 3.3.2.2 | Арга хэмжээ: Олдохын хүрэн бор тэмээний тоог өсгөх замаар сумдад | 2021-2024 | 3.0 ХХ | Сайжрагдсан тэмээний тоо | 2019 | 570 | 600 | Олдохын хүрэн бор 4000 омгийн тэмээний хавар, намрын ангилалтын ажлыг Хулд сумын | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулагчаар ашиглах | | | | | | | ЗДТГ, Хулд таван Эрдэнэ ХХК аж ахуй нэгжтэй хамран зохион байгуулж байна. Олдохын хүрэн бор омгийн 5 өсвөр буурийг шилэн сонгож, 100 ингэнд хээлтүүлэгчээр ашигласан байна. Хээл авалт 85%-тай ба сайжрагдсан тэмээний тоо 655 болоод байна. | |
| 3.3.2.4 | Арга хэмжээ: Аймгийн хэмжээнд үхэр сүргийн тоо, ашиг шимийг нэмэгдүүлэх | 2021-2024 | 12.0 УТ | ашиг шим нь нэмэгдсэн үхэр сүргийн тоо | 2020 | 0 | 70 | Баянжаргалан сумын нутгийн монгол үүлдрийн 800 үхэрт хувьсийн ангилалт, ээмэгжүүлэлтийн ажил хийгдсэн ба намрын ангилалтаар 200 үхэр цөм сүргийн ангийн шаардлага хангаж, ашиг шимийн түвшин 8 %-иар нэмэгдсэн. Дорнод монголын мухар улаан үүлдрийн 10 өсвөр хээлтүүлэгчийг 150 үнээнд сайжруулагчаар ашигласан. Хээл авалт 100%-тай байна. | 100 |
| 3.3.2.5 | Арга хэмжээ: Баянжаргалан сумын үхэр сүргийг "Дорнод монголын мухар улаан" үүлдрээр сайжруулах | 2021,2023 | 10.0 УТ | Тухайн жилд сайжрагдсан үхрийн тоо | 2020 | 0 | 10 | Дорнод аймгийн Халх гол сумаас Дорнод монголын мухар улаан үүлдрийн 10 бухан бяруу авах захиалгын дагуу 10 сая төгрөгний хөрөнгийг шийдвэрлэн авчирч орон нутгийн 10-н малчин өрхийн 150 гаруй үхэрт сайжруулагчаар ашиглаж байна. | 100 |
| 3.3.2.6 | Арга хэмжээ: Аймгийн тэмээ өсгөх бодлогыг хэрэгжүүлж бойжуулсан ботго тутамд урамшуулал олгох системийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулах | 2021-2024 | - | Бодлогын хэрэгжилтийн хувь | 2020 | 95 | 100 | Аймгийн тэмээ өсгөх бодлогыг хэрэгжүүлж бойжуулсан ботго тутамд урамшуулал олгох системийг орон нутгийн хэмжээнд бий болгохоор журам боловсруулан ажиллаж байна. Тэмээ өсгөх бодлогын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай байна. | 100 |
| 3.3.2.7 | Арга хэмжээ: Жилд 20-оос доошгүй стандартын | 2021-2024 | - | Бойжуулсан бухны тоо | 2019 | 974 | 984 | Сумдад стандартын шаардлага хангасан 25 өсвөр хээлтүүлэгч | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардлага хангасан бух бойжуулж үхэр сүргийг үе шаттайгаар сайжруулах | | | | | | | бойжуулаад байна. Нийт 999 бух бойжсон. | |
| 3.3.2.8 | Арга хэмжээ: Стандартын шаардлага хангасан цөм сүргийн ангийн хээлтэгч, хээлтүүлэгчийг эзэмжүүлэн бүртгэж, мэдээллийн нэгдсэн санд хамруулах | 2021-2024 | 2.2 ХХ | эзэмжүүлж бүртгэлжүүлсэн малын тоо/мя | 2019 | 90 | 93 | Мал эзэмжүүлэх, бүртгэлжүүлэх ажлын хүрээнд бод 1970, бог 17300 мал эзэмжүүлсэн. Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программыг ХХААХҮЯамнаас шинэчлэн, сайжруулалт хийгдэж байгаа тул эзэмжүүлсэн малыг бүртгэл мэдээллийн санд оруулах ажил хүлээгдэж байна. Нийт 109,2 мянган мал эзэмглэсэн | 100 |
| 3.3.3. | Зорилт: Нийт 7.4 сая га бэлчээрийн талбайн 70 хувьд бэлчээрийн даац 3 дахин илүү хэтрэлттэй байгаагийн 26 га талбайг 2024 гэхэд нөхөн сэргээнэ. | 2021-2024 | 148.0 | Тухайн жилд сэргээсэн талбайн хэмжээ (га) | 2020 | 0 | 5 | Аймгийн хэмжээнд 15,1 га-д бэлчээрийн олон наст ургамал тариалсан. 70,0 мянган га -д үлийн цагаан оготнотой тэмцэж, 51,5 га бэлчээрийн талбайг хашиж хамгаалсан байна. | 100 |
| 3.3.3.1 | Арга хэмжээ: Олон дахин хэтэрсэн болон талхлагдсан бэлчээрт олон наст ургамал цацах, тариалах, өнжөөж сэлгэж нөхөн сэргээх | 2021-2024 | 6.0 ХХ | Нөхөн сэргээгдсэн талбайн хэмжээ (га) | 2020 | 0 | 5 | 51,5 га бэлчээрийн талбайг хашиж хамгаалж, 15,1 га талбайд бэлчээрийн олон наст ургамал тариалж нөхөн сэргээх ажлыг зохион байгуулсан. | 100 |
| 3.3.3.2 | Арга хэмжээ: Дэрэн суман дахь тэжээлийн үйлдвэрийн хүчин чадлыг бүрэн ашиглаж аймгийн тэжээлийн нөөцийн 60-аас доошгүй хувийг үйлдвэрлэх | 2021-2024 | 51.0 ТХ | хүчин чадлын ашиглалтын хувь | 2020 | 0 | 15 | ХХААХХҮЯ, аймгийн ЗДТГ, “Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллага” “Гамшигт тэсвэртэй орон нутаг төсөл”-ийн 51,0 сая төгрөгийн санхүүжилтээр Дэрэн суманд 10 га талбайд тэжээлийн ургамал, ногоон тэжээл тариалсан. 10 хүний бүрэлдэхүүнтэй малчдын бүлэг үргац хураалтын ажлыг хийж 8 тн ургац хураан аваад байна. Гэсэн хэдий ч тэжээлийн | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үйлдвэрийг хариуцан ажиллуулах боловсон хүчний дутагдлаас болж тэжээл үйлдвэрлэлийн ажил хийгдээгүй. | |
| 3.3.3.3 | Арга хэмжээ: Айл өрхүүдийг өвөлжөө, хаваржааны эзэмшил газрын дэргэд нөөц бэлчээртэй болгох зорилгоор хашиж хамгаалж талбайн хэмжээг нэмэгдүүлэх | 2021-2024 | 10.0 ХХ | Хамгаалсан талбайн хэмжээ (мян/га) | 2019 | 267 | 272 | Сайнцагаан сумын 3, Өлзийт сумын 1, нийт 4 өрх өвөлжөө хаваржааны дэргэдэх бэлчээрийн 51,5 га бэлчээрийн талбайг хашиж хамгаалсан. Нийт 318,5 га бэлчээр хашиж хамгаалсан байна. | 100 |
| 3.3.3.4 | Арга хэмжээ: Бэлчээрийн хортон мэрэгч амьтан, шавьжтай байгаль орчин, хүн, малд халгүй технологи ашиглан тэмцэх ажлыг зохион байгуулах | 2021-2024 | 254.4 УТ | Тэмцсэн талбайн хэмжээ (мян/га) | 2020 | 100 | 130 | Улсын төсвийн 7 сумын 50,0 мян.га бэлчээрийн талбайд энгийн механик аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулсан. Нийт 150,0 мян.га талбайд тэмцсэн. | 100 |
| 3.3.3.5 | Арга хэмжээ: Малын бэлчээрийн талбайг гүн өрмийн худаг болон энгийн уурхайн худгаар усжуулж, сэргээгдэх эрчим хүчийг ашиглах | 2021-2024 | ОУТ-205.3 ОНС-347.0 Малчид - 4.0 | Тухайн жилд шинээр гаргах худгийн тоо | 2019 | 3382 | 3 | ЗЗББУХТөсөл, ОНХСангийн хөрөнгөөр 4-н суманд инженерийн хийцтэй гүн өрмийн худаг 10, “Шинэ хөдөө” төслөөр 2 суманд 2 худаг, ЗЗББУХТөсөл, ОНХСан, Малчдын хөрөнгөөр 5-н суманд нийт 44 энгийн уурхайн худгийг сэргээн засварлаад байна. ОНХСангийн хөрөнгөөр 2 суманд 16 цооног гаргасан. | 50 |
| | | | - | Сэгээгдэх эрчим хүчний тоо | 2020 | 1 | 2 | Юнидо төслийн шугамаар холбогдох тоо судалгааг хийж байна. | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3.3.4 | Зорилт: 2020 онд мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад 650 мянган толгой мал хамруулсныг 2024 онд 200 мянган толгой мал болгож вакцингүй эрүүл малын эзлэх хувийг нэмэгдүүлнэ. | 2021-2024 | ОНт 435.0 | Хамруулсан малын тоо (мян/төл) | 2020 | 650.0 | 4-30.0 | Галзуу 34.4, дотрын халдварт хордлого 247.3, дуут 6.0, цусан халдварт 1.0, шөвөг яр 117.5, сахуу 6.0 нийт 432.9 малыг дархлаажуулалтанд хамруулсан. Дуут, цусан халдварт, ДХХ-Энтеробактериозийн хам вакцинуудын үйлчилгээний хөлсөнд орон нутгийн хөгжлийн сангаас 210 сая төгрөг, вакцины үнэд 35.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс тус тус олгосон. | 100 |
| 3.3.4.1 | Арга хэмжээ: Мал эмнэлгийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлж, мал эмнэлгийн гэрчилгээ олгох | 2021-2024 | ОНТ 55.0 | Гэрчилгээний тоо | 2020 | 15000 | 16000 | 2021 оны 10 сараас малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хүнсний болон худалдааны зориулалтаар гэрчилгээ бичиж эхэлсэн нийт 17692 мал эмнэлгийн гэрчилгээ бичигдсэн байна. | 100 |
| 3.3.4.3 | Арга хэмжээ: Сум бүрийг вакцин хадгалах хөргүүр, багуудыг мал угаалгын ванн, мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлэх хашаа барих | 2021-2024 | ОНТ 100.0 | шинээр нэмэгдсэн мал угаалгын ванны тоо | 2020 | 15 | 20 | Зах Зээл Бэлчээрийн Удирдлагын Хөгжил хөтөлбөрийн санхүүжилтээр Өлзийт сумын Тагт багт 1 , Дэрт багт 1, Өндөршил сумын Цог багт 1, Талын нар багт 1, нийт 4 мал угаалгын ванн ашиглалтад оруулсан. Дэлгэрхангай сумын Шавагтай багт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн хөрөнгө оруулалтаар 1 ванн барьж, нийт 5 мал угаалгын ванн ашиглалтад оруулсан.Нийт 20 мал угаалгын ваннтай болсон. | 100 |
| | | 2021-2024 | ОНТ 80.0 | мал эмнэлгийн ажил үйлчилгээ үзүүлэх хашааны тоо | 2020 | 0 | 8 | Өндөр шил суманд 2, Адаацаг суманд 2, Өлзийт суманд 2, Луус суманд 1, Сайхан-Овоо суманд 1, нийт 8 мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх зөөврийн хашааг төсөл хөтөлбөр болон хувийн мал эмнэлгийн нэгжийн хөрөнгөөр авч, мал эмнэлгийн ажил үйлчилгээ | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | үзүүлэхэд ашиглаж байна. | |
| **3.4 Аялал жуулчлал** | | | | | | | | | |
| 3.4.1 | Зорилт: Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн гадаад жуулчдын тоог 26000-д хүргэнэ. | 2021-2024 | УТ 45.0 | Дундговь аймагт ирсэн гадаад жуулчдын тоо | 2019 | 19540 | 19740 | Тусгай сонирхлын болон аялалаар 19756 гадаад жуулчин аймагт ирж үйлчилгээ авсан байна. Аймгийн байгалийн үзэсгэлэнт газрууд болон жуулчны бааз, зочид буудлуудаар гадаад, дотоодын нийт 35204 жуулчин үйлчлүүлсэн. | 100 |
| 3.4.1.1 | Арга хэмжээ: Жуулчдад үзүүлэх уламжлалт зан заншил, нутгийн онцлогтой эвент арга хэмжээг нэмэгдүүлэх. | 2021-2024 | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 2019 | 4 | 5 | Аймгийн шагайн холбоо “Наран хөгцтий” шагайн тойрмыг Дэрэн сумын Нарангийн энгэрт 08 дугаар сарын 22, 23-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус тэмцээнд 13 сумын 32 багийн 186 харваачид оролцсон. | 100 |
| 3.4.1.4 | Арга хэмжээ: Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд жил бүр нэгдсэн зохион байгуулалттай оролцож, /хятад, солонгос, англи гэх зэрэг хэл дээр видео контентууд хийж/ орон нутгаа сурталчилна. | 2021-2024 | - | Гадаад жуулчдыг хүлээн авах байгуулсан гэрээний тоо | 2020 | 100 | 100 | БОАЖЯамны дэмжлэгтэй www.ihotel.mn-тэй хамтран аймгийн байгалийн үзэсгэлэнт газруудын танилцуулга, видео контентыг хийж цахим үзэсгэлэн зохион байгуулсан. Цахим үзэсгэлэнд аймгийн 4 жуулчны бааз оролцож 105 зочин хүлээж авах урьдчилсан захиалга хийсэн.<br>“Ай Ти Эм – Монгол” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн 10 сарын 28-30-ны өдөр зохион байгуулагдсан. Үзэсгэлэнд 8 аж ахуйн нэгж, байгууллага оролцож 1500 брошур тарааж, жуулчин хүлээн авах 60 гэрээ байгуулсан. **Нийт 2 үзэсгэлэнд 165 жуулчин хүлээн авах гэрээ байгуулсан.** | 100 |
| 3.4.1.5 | Арга хэмжээ: Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж нүүдлийн соёл, иргэншлийг харуулсан морь, тэмээн | 2021-2024 | - | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | - | - | 2 | Адаацаг сумын “Сүм хөх бүрд” байгалийн үзэсгэлэнт газарт Улсын Аварга малчин Бүдсүрэнтэй хамтран “Адуучин тэмцээн”-ийг зохион байгуулсан. Тэмцээнийг 70 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | аялал, язгуур урлаг, өв соёлын арга хэмжээ зохион байгуулах | | | | | | | иргэд, аялагчид үзэж сонирхсон. “Мажисти Монголиа” ТББ-тай хамтран Бага газрын чулууны ууланд үйл ажиллагаа явуулдаг “Говийн хүрхрээ” жуулчны баазад “Spirit of gobi” хөгжмийн фестивалийг зохион байгуулсан. Тус фестивальд Монголын контемпорари урлагийн төлөөлөл, дүрслэх урлаг, электроник хөгжмийн 38 уран бүтээлч, бүтээлээ толилуулж 216 аялагчид оролцсон. Нийт 2 арга хэмжээ зохион байгуулав. | |
| 3.4.1.7 | Арга хэмжээ: Аялал жуулчлал, Зочлох үйлчилгээний төрөлжсөн сургалтыг салбарын ажилтнууд болон иргэдийг хамруулж боловсон хүчнийг бэлтгэх | 2021-2024 | УТ 5.0 | Тухайн жилд сургалтад хамрагдсан иргэдийн тоо | 2020 | 120 | 130 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Бүгд найрамдах Солонгос улсын Засгийн газартай хамтран зохион байгуулсан “Зочлох үйлчилгээ, хөтөч тайлбарлагч бэлтгэх” цахим сургалтад 30 үйлчилгээний ажилтан, иргэд хамрагдаж сертификат авсан. “Хорека софт” болон “Говийн шуранхай” аялал жуулчлалын холбоотой хамтран "Зочлох үйлчилгээ ба манлайлал" сургалтад жуулчны бааз, зочид буудлын эрхлэгч менежер 12, “Зочлох үйлчлэх салбарын сургалт хөгжлийн төв” ТББ-тай хамтран “Ковидын дараах борлуулалтын хэв маяг” сэдэвт сургалтад жуулчны бааз, зочид буудал 10, “Соёлын болон түүхэн аялал жуулчлалын хөтөч, тайлбарлагч бэлтгэх” цахим сургалтад 28, Орон нутгийн хөгжил ба аялал жуулчлал: ХБНГУ-ын Бавaар мужийн Эдийн засаг, эрчим хүч, бүс нутгийн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хөгжлөөс суралцах цахим сургалтад 15, Аялал жуулчлалын хөгжлийн төвөөс зохион байгуулсан “Аюулгүй аяллын шошго олгох” цахим сургалтад 12, Хямралын дараах үеийн боломж сургалтад 14, “Ай Ти Эм” аялал жуулчлалын үзэсгэлэнгийн хүрээнд зохиогдсон сургалтад 11 хүн тус тус хамрагдлаа. Нийт 8 удаагийн цахим сургалтад давхардсан тоогоор 132 удирдлага, мэргэжилтэн, үйлчилгээний ажилчид хамрагдсан. | |
| 3.4.1.8 | Арга хэмжээ: Аялал жуулчлалын газруудын үйлчилгээний стандартын хэрэгжилтийн дундаж үнэлгээг 90 хувьд хүргэх | 2021-2024 | - | Үнэлгээний дундаж хувь | 2020 | 80 | 83 | Аялал жуулчлалын газруудын үйлчилгээний стандартын хэрэгжилт ийн дундаж 84 хувьтай байна. | 100 |
| 3.4.1.10 | Арга хэмжээ: Өлзийт, Гурвансайхан сумдад аялал жуулчлалын цогцолбор байгуулах | 2021-2022 | | Цогцолборын тоо | 2020 | 0 | 1 | “Эрдэнэс силвер рисурс” ХХК-аас Их газрын чулуу байгалийн цогцолбор газарт байгуулах “Эрдэнэс ресорт” жуулчны баазын төсөл, техник эдийн засгийн үнэлгээг “Саруул консалтинг” ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн. Төслийг хэрэгжүүлэх төсөвт өртөг 4.8 тэрбум төгрөг. Төсөл хэрэгжүүлэх хүрээнд Гурвансайхан сум, Их газрын чулууны байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас газар ашиглалт болон холбогдох бичиг баримтыг хуулийн хүрээнд олгосон. | 0 |
| **3.5 Эрчим хүч** | | | | | | | | | |
| 3.5.1 | Зорилт: Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах | 2021-2024 | 69.1 ОНХС | Тухайн жилд ашиглалтад орсон ажлын тоо | 2020 | 2 | 4 | 4 төсөл арга хэмжээний ажил хүлээн авсан. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | агаарын шугам, дэд станц, дэд бүтэц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр хангана. | | | | | | | | |
| 3.5.1.1 | Арга хэмжээ: Аймгийн төвийн 0,4кв-ын хуваарилах сүлжээг 100 хувь шинэчилж, ашиглалтад оруулах | 2021-2022 | 2,680.00 ГХ | Ажлын гүйцэтгэлийн хувь | 2020 | 0 | 80 | Аймгийн төвийн 0,4кв-ын хуваарилах сүлжээг 100% шинэчлэх, хэрэглэгчдийн цахилгаан эрчим хүчний тоолуурыг ухаалаг тоолуураар солих ажлыг “Проект ватт” ХХК-тай 4,6 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. 4800ш ухаалаг тоолуур солихоос 1000ш ухаалаг тоолуур суурилуулсан. 52км 0,4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татахаас 50км угсарсан. Ажлын гүйцэтгэл 80 хувьтай. БНХАУ-ын хэл хаагдсанаас материал байхгүйгээс энэ жилийн ажил зогссон. | 100 |
| 3.5.1.2 | Арга хэмжээ: Аймгийн төвийн дулааны станцын ажлыг эхлүүлэх | 2021-2024 | - | Ажлын гүйцэтгэл хувь | 2020 | 0 | 5 | Эрчим хүчний яам “10 аймгийн төвд дулааны станц барих төсөл”-ийн төсөл хэрэгжүүлэх нэгж дээр 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдөр аймгийн төвийн дулааны станцын гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг зарлан 2021 оны 09 дугаар сарын 15-нд тендер нээж, үнэлэх шатандаа явагдаж байна. | 0 |
| 3.5.1.4 | Арга хэмжээ: Эрчим хүч хэмнэх арга хэмжээний хүрээнд хэрэгжүүлэх ажлуудын хөрөнгийг шийдвэрлэх | 2021-2024 | 15.0 ОНХС | Хөрөнгийн асуудал шийдвэрлэсэн эсэх (тийм-1, үгүй-0) | 2020 | 2 | 1 | Аймгийн төвийн 6, 7, 8 байрны гадна фасад, тохижилт, дээврийн зураг, төсөв боловсруулан ажлыг “Скеч” ХХК-тай 15 сая төгрөгийн гэрээ байгуулан 2021 оны 7 дугаар сард хүлээлгэн өгсөн. Мөн 18 дугаар байрны гадна фасадын засварын ажлыг “Хүрэнжинсний-Овоо” ХХК-тай 2021 оны 10 дугаар | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | сарын 20-ны өдөр 139,030,033 төгрөгийн гэрээ байгуулан хүлээн авсан. | |
| 3.5.1.5 | Арга хэмжээ: Аймгийн төвд шинээр баригдах дулааны станцын цахилгааны эх үүсвэр холбох 220/110/35кВ "Мандал" дэд станцын өргөтгөлийн ажлыг ашиглалтад оруулах | 2021 | - | Ажлын гүйцэтгэл хувь | 2020 | 10 | 100 | Эрчим хүчний яам "Гэгээн цайтан" ХХК-тай 410,105,600 төгрөгийн гэрээ байгуулан хүлээн авсан. | 100 |
| 3.5.1.6 | Арга хэмжээ: Аймгийн төвийн шинэ суурьшлын бүс болон шаардлагатай сумдын төвийн цахилгааны хангамжийг сайжруулах ажлын хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх | 2021-2022 | 252.3 ОНХС | Тухайн жилд хөрөнгийн асуудал шийдвэрлэсэн ажлын тоо | 2020 | 0 | 2 | Луус сумын төвийн 0.4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөлийн ажлыг “Цацрах хангай” ХХК-тай 69,121,267 төгрөгийн гэрээ байгуулан 2021 оны 9-р сард хүлээлгэн өгсөн.<br>Сайнцагаан сумын Далай хорооллын 0.4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг “Спэйшлтим ап” ХХК-тай 229.7 сая төгрөгийн гэрээ байгуулан хүлээн авсан.<br>Хулд сумын 0.4кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын ажлыг БЗӨБ ЦТС ТӨХК-ийн Дундговь цахилгаан түгээх сүлжээ ХХК 2022 онд хийхээр төлөвлөн ажилалж байна. | 100 |
| **3.6 Тээвэр, логистик** | | | | | | | | | |
| 3.6 | Зорилт: Аймгийн тээвэр, мэдээлэл, холбооны салбарын ДНБ 2019 онд 5328.6 сая төгрөг байгааг 2024 онд 5386.1 сая төгрөгт хүргэнэ. | 2021-2024 | 4,200.0 | Дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ (сая/төг) | 2019 | 5328.6 | 5351.6 | Жилийн сүүлээр дотоодын нийт бүтээгдэхүүний тооцоолол гарна. | - |
| 3.6.1.1 | Арга хэмжээ: Аймгийн төвд ачаа буулгах, хадгалах, шилжүүлэн ачих томоохон | 2021 | - | Газрын асуудлыг шийдвэрлэсэ | 2020 | 0 | 1 | Сайнцагаан сумын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд газрын байршлыг | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | терминал логистикийн төв байгуулах. | | | н эсэх (тийм-1, үгүй-0) | | | | тусгаж Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлагдан шийдвэрлэсэн. | |
| 3.6.1.2 | Арга хэмжээ: Арвайхээр-Мандалговь-Чойр чиглэлийн авто замын ажилд анхаарч хамтран ажиллах | 2021-2024 | 500.0 УТ | Холбогдох байгууллагатай хамтарч ажилласан эсэх (тийм-1, үгүй-0) | 2020 | 0 | 1 | Зам, тээврийн хөгжлийн яам нь “Эм Си Пи Си Жи Ар” ХХК-тай 1,600,103,376 төгрөгийн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 95 хувьтай магадлалаар хянагдаж байна. Орон нутгийн зүгээс дайран өнгөрч буй сумдаас газрын захирамж гарган хүргүүлсэн. | 100 |
| 3.6.1.4 | Арга хэмжээ: Мандалговь-Улаанбаатар, Мандалговь-Даланзадгад чиглэлийн Улсын чанартай хатуу хучилттай авто замын арчилгаа, засварын ажилд хяналт тавьж, орон нутгийн авто замын засвар, арчилгааны хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх | 2021-2024 | 1,000.0 УТ 31.9 ОНТ | Хөрөнгийн асуудал шийдвэрлэн хяналт тавьсан эсэх (тийм-1, үгүй-0) | 2020 | 1 | 1 | Зам, тээврийн хөгжлийн яаманд Дундговь аймаг дахь зам хариуцагчийг сонгон шалгаруулах тендерийг зарлан Дундговь авто зам ХХК шалгаран 1,186,510,000 төгрөгийн гэрээ байгуулан засварын ажлыг хийж дууссан.<br>Орон нутгийн авто замын засварыг 2020 онд аймгийн төвийн нөхөөсийн ажлыг “Дэвжих-Эрдэнэ” ХХК 2021 оны 9 дүгээр сард хүлээлгэн өгсөн. Мөн Хот тохижуулах газар өөрийн хөрөнгөөр үлдсэн нөхөөсийн засварыг хийж дууссан. | 100 |
| **4.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО** | | | | | | | | | |
| 4 | Зорилго: Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийн сэтгэл ханамж 2019 онд 65.8 хувьтай байгааг 2024 онд 78.6 хувьтай болгож нэмэгдүүлнэ. | 2021-2024 | - | Иргэдийн сэтгэл ханамжийн түвшин хувь | 20 | 65.8 | 69 | Иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмжийн сэтгэл ханамжыг улсын нэгдсэн дүнг авч хэрэглэхээр төлөвлөсөн боловч улсын хэмжээнд нэгдсэн дүн гараагүй | - |
| **4.1 Цахим Монгол- төрийн шуурхай үйлчилгээ** | | | | | | | | | |
| **4.1.1** | Зорилт: Дижитал шилжилт хийх замаар төрийн байгууллага хоорондын болон иргэн, хувийн хэвшлийн цахим | 2021-2024 | ОНТ 60.7 | Төрийн цахим үйлчилгээний E-mongolia систем, цахим төслийн | 2020 | 10 | 20 | Төрийн цахим үйлчилгээний E-mongolia системийг нэвтрүүлж, төрийн байгууллага хоорондын болон иргэн, хувийн хэвшлийн | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн солилцоо, эргэх холбооны чадавхийг 2020 онд 10 хувьтай хэрэгжиж байгааг 2024 онд 80 хувьд хүргэнэ. | | | хэрэгжилтийн хувь | | | | цахим мэдээллийн солилцоог хангах зорилгоор 12 төрлийн үйл ажиллагааг цахимжуулан төслийн хэрэгжилт 20 хувьтай байна. | |
| 4.1.1.1 | Арга хэмжээ: "Цахим төр-Ухаалаг Дундговь" цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх | 2021-2024 | ОНТ 95.0 | Хэрэгжилтийн хувь | 2020 | 10 | 20 | Төрийн байгууллагуудын мэдээллийн урсгалыг нэмэгдүүлж, зохион байгуулалтыг сайжруулах, нэгдсэн удирдлагатай болгох зорилготой Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн цахим ERP системийг нэвтрүүлж, тус системийг аймгийн хэмжээнд 141 төрийн байгууллагын 2493 төрийн албан хаагч үйл ажиллагаандаа ашиглаж байна. ERP системийг нэвтрүүлснээр төрийн байгууллагын иргэдийн санал хүсэлт өргөдөл гомдлын бүртгэл, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа, ажлын цагийн бүртгэл зэрэг нийт 12 төрлийн үйл ажиллагаа цахимжлаа. Төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Нээлттэй утас-7059106” дугаарын үйл ажиллагааг дуудлагын төв /Call center/-ийн систем рүү шилжүүлж, бүх сумдыг IP технологид суурилсан шинэ үеийн НЭЭЛТТЭЙ суурин утас, интернэтийн домайн хаягтай болгож,<br>Газрын кадастрын цахим систем болох www.egazar.gov.mn цахим хуудаснаас цаг хугацаа, орон зайнаас үл хамааран газрын харилцаатай холбоотой 17 | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | төрлийн үйлчилгээг авах боломжтой болсон. Сумдын интернетийн бодит хаягтай болгож, хурдыг нэмэгдүүлж хамгийн багадаа deticait 5 mb болгосноор цахим хурлын системээр хурал, мэдээлэл хийх боломжийг бүрдүүлсэн. Тус ажлын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газарт 60.0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар 86 инчийн ухаалаг дэлгэц, 3*4 метрийн харьцаатай ЛЕД самбар зэрэг техник, тоног төхөөрөмжөөр хангаад байна. | |
| 4.1.1.3 | Арга хэмжээ: Аймаг, сумдын удирдлагууд иргэдтэй хийх уулзалт, арга хэмжээг сар бүр зохион байгуулах | 2021-2024 | ОНТ 5.0 | Хамрагдсан иргэдийн тоо | 2020 | 0 | 4000 | Ковид-19 цар тахалтай холбоотой иргэдийн бөөгнөрөл үүсгэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор уулзалтын цагийг ажлын өдрүүдэд цаг харгалзахгүй хүлээн авч уулзаж хэвшсэн.<br>Аймаг, сумдын Засаг дарга нар нийт 4180 иргэдтэй уулзалт зохион байгуулан санал хүсэлтийг хүлээн авч ажилласан. | 100 |
| 4.1.1.4 | Арга хэмжээ: Төрийн архивын баримтын 95-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, иргэдэд архивын үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх | 2021-2024 | ОНТ 16.2 | Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын хувь | 2020 | 90 | 91 | Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа 1980-2016 оны нийт 3600 удирдлагын баримтаас 3288 баримтыг цахим санд оруулж иж бүрэн хувь үүсгэсэн ба 91,3 хувийн хэрэгжилттэй байна.<br>Тус онд нийт 1254 иргэний хүсэлтийг хүлээн авч 341 иргэнд лавлагаа, 913 иргэнд хувь хуулбар гарган өгч, нийт 1300 гаруй лавлагаа, хуулбар гаргаж үйлчилсэн. Эдгээр лавлагаанд давхардсан тоогоор 6630 гаруй хадгаламжийн нэгжийг мэдээлэл лавлагааны ажилд ашиглуулсан. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.1.1.5 | Арга хэмжээ: Төрийн архивт нягтруулсан шүүгээ болон бусад техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангаж, архивын баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах | 2021-2024 | ОНТ 7.1 | Нягтруулсан шүүгээ болон бусад тоног төхөөрөмжийн хангалтын хувь | 2020 | 50 | 70 | Төрийн архивт хэрэглэгдэж байгаа тоног төхөөрөмжийг шинэчлэх, нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж суурин компьютер, хурдын скайнер, олон үйлдэлт канононоор хангаж, мөн төрийн архивын 2 хадгаламжийн сангийн шалыг хулдааслаж тохижуулсан. Архивын баримт бичгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах үүднээс нягтруулсан 2 шүүгээтэй болсон.<br>Тоног төхөөрөмжийн хангалт 75 хувьтай байна. | 100 |
| 4.1.1.6 | Арга хэмжээ: Иргэний бүртгэлийн үйлчилгээний төлбөрийн "Гэрэгэ" систем нэвтрүүлж, мэдээллийн санд төрөлтийн бүртгэл алдаатай, дутуу бүртгэгдсэн 8200 иргэний зөрчлийг бүрэн арилгах | 2021-2024 | ОНТ 3.5 | -<br>Үйлчилгээний төлбөрийн систем нэвтрүүлсэн эсэх<br>-Тухайн жилд зөрчилгүй болсон иргэний тоо | 2020 | 1/8200 | 1/2050 | Аймгийн нэг цэгийн үйлчилгээний танхимд "Гэрэгэ" киоск машиныг суурилуулан ажиллуулж, уг киоск машинаар төрийн болон төрийн бус 55 байгууллагын 600 гаруй төрлийн үйлчилгээний төлбөрийг төлөх боломжийг бүрдүүлж, 136 иргэн 8 төрийн байгууллагын төлбөр хураамжийг төвлөрүүлэн үйлчлүүлсэн байгаа нь төрийн үйлчилгээний шат дамжлага буурч иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлсэн.<br>Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээлэл технологийн газраас мэдээллийн санд төрөлтийн бүртгэл алдаатай, дутуу бүртгэгдсэн 18-аас доош насны 8200 хүүхдийн бүртгэлийг аймгийн хэмжээнд гаргуулан авч зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулан жилд 2050 хүүхдийн төрөлтийн бүртгэлийн зөрчлийг арилгахаар төлөвлөн тус онд 1800 хүүхдийн төрөлтийн бүртгэлийг мэдээллийн | 93.9 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | санд зөрчилгүй болгосон үр дүн гарсан. | |
| | **4.2 Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба** | | | | | | | | |
| **4.2** | Зорилго: Төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, ёс зүйн хариуцлагыг нэмэгдүүлж, сахилга, хариуцлага, ёс зүйн зөрчил 2020 онд 10 хувьтай байсныг 2024 онд 4 хувиар бууруулна. | 2021-2024 | 83.2 | сахилга, ёс зүйн хариуцлага зөрчлийн бууралт хувь | 2019 | 10 | 9 | Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн дагуу ажлын хариуцлага, ТАХ-ын ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгон ажиллах чиглэлийг 23 агентлаг 15 сумдын удирдлагуудад өгч ажиллалаа.<br>2021 онд аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний хэлтэс агентлаг, 15 сумын 64 төрийн байгууллагын Ёс зүйн зөвлөл үйл ажиллагаа явуулж 49 удаагийн хурал, 69 удаагийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж 1801 төрийн албан хаагчийг хамруулан, төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйтэй холбоотой 16 өргөдөл, гомдол ирснийг хэлэлцэн шийдвэрлэж, 5 төрийн албан хаагчид “Сануулах”, 6 албан хаагчид “Уучлал гуйлгах”, 5 төрийн албан хаагчид байгууллагын даргын шийдвэрээр хариуцлагыг ногдуулсан байна. Сахилга, ёс зүйн хариуцлага зөрчлийн бууралт 9.3 хувьтай байна. | 100 |
| 4.2.1 | Зорилт: Орон нутагт шаардлагатай боловсон хүчний нөөц бүрдүүлэн томилгооны зөрчлийг 2020 онд 33.2 хувь байсныг 2024 онд 13.3 хувиар бууруулна. | 2021-2024 | 30.0 | томилгооны зөрчлийн бууралт хувь | 2020 | 33.2 | 23.3 | Орон нутагт нэн шаардлагатай боловсрон хүчний нөөцийг бүрдүүлэх зорилгоор Төрийн жинхэнэ албан хаагчийн ерөнхий болон тусгай шалгалтыг зохион байгуулж төрийн захиргааны албан тушаалын зөрчилтэй 108 томилгоонoос 41 орон тоо сонгон | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | шалгаруулалтаар нөхөгдөж томилгооны зөрчил 15,7 хувиар буурсан байна. | |
| 4.2.1.1 | Арга хэмжээ: Улс төрөөс хараат бус, чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцсэн мэргэшсэн тогтвортой төрийн албыг бэхжүүлэх | 2021-2024 | ОНТ 5.0 | Шатлан дэвшсэн төрийн албан хаагчдын хувь | 2020 | 10 | 15 | Төрийн албаны тухай хууль, чадахуйн зарчим, шатлан дэвших тогтолцоонд нийцүүлэн 24 төрийн албан хаагчийг шатлан дэвшүүлэн ажиллуулснаар төрийн албан хаагчдын 17,5 хувь нь шатлан дэвшин ажиллаж байна. | 100 |
| 4.2.1.2 | Арга хэмжээ: Иргэнийг төрийн албан тушаалд томилсны дараа богино болон дунд хугацааны сургалтад орон зай, цаг хугацаанаас үл хамааран бүрэн хамруулах | 2021-2024 | ОНТ 83.2 | Богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо | 2020 | 46 | 92 | Удирдлагын академийн Төрийн жинхэнэ албан тушаалд анх томилогдсон 13 албан хаагч, Дунд хугацааны мэргэшүүлэх давтан сургалтанд 13 төрийн жинхэнэ албан хаагч, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 10, эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3 албан хаагчийг тус тус хамруулж, нийт 39 албан хаагчийг мэргэшүүлэх багц сургалтад хамруулсан. Мөн богино хугацааны сургалтад 70 албан хаагчийг хамруулсан. Нийт 109 албан хаагчийг хамруулаад байна. | 100 |
| 4.2.1.3 | Арга хэмжээ: Засгийн газар болон аймгийн захиалгаар дотоод, гадаадад суралцагчидтай гэрээ хийж, тэдний сурч мэдсэн зүйлийг аймагтаа хэрэгжүүлэхэд хамтран ажиллах | 2021-2024 | ОНТ 30.0 | Гэрээ байгуулсан оюутны тоо | 2020 | 0 | 3 | Аймгийн “Хүний нөөцийг хөгжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд орон нутагт нэн шаардлагатай байгаа МУБИС-д суралцаж байгаа 2022 онд төгсөх математикийн багш-2, Бага ангийн багш-2, Химийн багш-1, АУИС-д их эмч мэргэжлээр суралцаж байгаа төгсөх курсийн 7 оюутан, Глабал удирдагч сургуульд сувилагч мэргэжлээр суралцаж байгаа төгсөх курсийн 18 оюутан, ХААИС-д суралцаж байгаа Малын их эмчээр суралцаж байгаа 4 оюутан, | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Мал зүйч мэргэжлээр суралцаж байгаа 1 оюутан нийт 35 оюутантай гэрээ байгуулан сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлж орон нутагт нэн шаардлагатай байгаа боловсон хүчнийг бэлтгэн орон нутагтаа татан авч ажиллуулахаар болоод байна. | |
| 4.2.2 | Зорилт: Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлж, бүх шатанд шударга ёсыг эрхэмлэсэн иргэд, олон нийтийн хандлагыг төлөвшүүлнэ. | 2021-2024 | - | Шударга байдлын үнэлгээ хувь | 2019 | 69.8 | 70.5 | Шударга байдлын үнэлгээ тус онд хийгдсэн хэдий ч одоогоор эцсийн үнэлгээ дүгнэгдэж гараагүй.Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, авлига, хүнд сурталгүй “***Дундговь авлигагүй хөгжинө”*** уриалгыг санаачлан хэрэгжүүлсний үр дүнд төрийн байгууллагуудын цахим хуудасны үнэлгээгээр тус онд улсын хэмжээнд аймгуудаас 86.8 хувьтай үнэлэгдэж тэргүүлсэн. Авлигатай тэмцэх газраас 2 жил тутамд хийгддэг төрийн байгууллагуудын Шударга байдлын үнэлгээ 72.8 хувьтай дүгнэгдсэн нь өмнөх түвшнээс 3 функтээр нэмэгдсэн үр дүн гарсан. ХАСУМ хянуулсан дүгнэлт/албан бичиг/-ийг аймгийн www.dundgovi.gov.mn сайтны Ил тод байдал хэсгийн Авлигатай тэмцэх үйл ажиллагаа хэсэгт, ХАСУМ хянуулсан 18 дүгнэлтийг байршуулан ил тод нээлттэй сурталчилж шударга байдлыг ханган ажиллаж байна. | 100 |
| 4.2.2.1 | Арга хэмжээ: Авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх төрийн бодлого, хууль тогтоомжийг иргэд, олон нийтийн оролцоотой | 2021-2024 | - | Авлигаас урьдчилан сэргийлэх тухайн жилийн | 2019 | 80 | 85 | Аймгийн ЗДТГ-ын 2021 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээг иргэд, олон нийт, аймгийн төлөөлөгч нараас ирүүлсэн | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хамтран хэрэгжүүлэх. | | | төлөвлөгөөни й хэрэгжилт хувь | | | | саналын дагуу 15 зорилго, 65 арга хэмжээтэй төлөвлөн боловсруулж, аймгийн Засаг даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөг Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлаг, сумдад дүгнэх хуудасны хамт хүргүүлэн сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга нарт уг төлөвлөгөөг хэрхэн хэрэгжүүлж ажиллах талаар арга зүйн семинар, сургалтыг зохион байгуулж тус төлөвлөгөөний хэрэгжилт 91.4 хувийн гүйцэтгэлтэй байна. | |
| 4.2.2.2 | Арга хэмжээ: Сум, байгууллагын эрх бүхий албан тушаалтан(ЭБАТ)-уудыг жил бүр чадавхжуулж, тогтвор суурьшилтай ажиллуулах. | 2021-2024 | | ЭБАТ-ны сургалт, семинарт хамралтын хувь | 2019 | 80 | 90 | 2021 оны мэдүүлгийн бүрдүүлэлтийн үйл ажиллагааны цахим семинар сургалтанд төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах салбар 49 эрх бүхий албан тушаалтнуудыг 100 хувь оролцуулан чадавхжууллаа. | 100 |
| 4.2.3 | Зорилт: Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хууль, эрх зүйн сургалт, сурталчилгаа, тусламж, үйлчилгээг жил бүр нийт иргэдийн 10-аас доошгүй хувьд хүргэнэ. | 2021-2024 | ОНТ 3.0 | Тухайн жилд эрх зүйн сургалт, сурталчилгаа нд хамрагдсан иргэдийн хувь | 2019 | 10 | 12 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг цахим хэлбэрээр дээшлүүлэх зорилт тавин сумдын “Эрх зүйн хөтөч”-үүдтэй хамтран ажилласны үр дүнд нийт 5238 иргэн буюу 12 хувьд эрх зүйн туслалцаа үйлчилгээ үзүүллээ. | 100 |
| 4.2.3.1 | Арга хэмжээ: Иргэд, олон нийтэд чиглэсэн нэгдсэн хууль зүйн тусламж, үйлчилгээ сургалт, сурталчилгааг жил бүр 3-аас доошгүй сумдад зохион байгуулах | 2021-2024 | ОНТ 3.0 | тухайн жилд хууль зүйн сургалт, сурталчилгаа зохион байгуулсан сумдын тоо | 2019 | 2 | 3 | Аймаг, сумдын “Эрх зүйн хөтөч”, “Насан туршийн боловсрол” зэрэг цахим хаягуудаар иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлж, Эрх зүйн хөтчүүдийг удирдлага зохион байгуулалтаар ханган “Иргэн бүрт эрх зүйн боловсролыг цахим хэлбэрээр | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | хүргэх 3 сарын аян"-ыг аймгийн хэмжээнд 15 суманд зохион байгуулж Аймаг, сумдын Эрх зүйн хөтөчүүдээс бэлтгэн боловсруулсан цахим гарын авлага, брошур, кино, шторк, мэдээ, мэдээлэл, сургалт, сурталчилгааг давхардсан тоогоор 238 удаа, 5238 хүнд хүргэж, 26637 удаагийн хандалт авч, бүх сумдад хүрч ажилласан үр дүн гарч Аймгийн ГХУСАЗСЗ-өөс зохион байгуулсан Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг "Сум бүрт" нээлттэй өдөрлөгөөр хууль хяналтын байгууллагуудтай хамтран Дэлгэрцогт, Луус, Хулд сумдын 311 хүнд эрх зүйн сургалтыг зохион байгуулсан. | |
| 4.2.3.2 | Арга хэмжээ: Хүний эрхийг хамгаалах төр, иргэний байгууллагын хамтын ажиллагааг бэхжүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа, үйлчилгээ үзүүлэх | 2021-2024 | - | Хүний эрхийн Үндэсний комисст гаргасан СӨГ-ын шийдвэрлэлтийн өсөлт хувь | 2019 | 82 | 86 | Хууль хяналтын байгууллагууд хамтран эрх зүйн сургалт, сурталчилгааг цахим хэлбэрээр зохион байгуулан, хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч эрүүгийн 35 хэргийн төлбөрийн чадваргүй 42 холбогдогчдод өмгөөллийн үйлчилгээг үзүүлж, хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөөг 305 иргэнд үзүүллээ. Аймаг дахь ХЭҮК-ийн референтэд 3 гомдол хүлээн авч гомдлыг 100 хувь шийдвэрлэсэн. | 100 |
| 4.2.3.3 | Арга хэмжээ: Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт сургалтыг орон нутагт зохион байгуулах | 2021-2022 | ОНТ 5.0 | Сургалтанд хамрагдсан удирдлага, албан хаагчдын тоо | 2020 | 0 | 20 | Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт болон төсөвлөлт сургалтыг 25 байгууллагын удирдлагуудад, сумдын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн 15 дарга нар нийт 40 хүнд зохион байгууллаа. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.2.3.4 | Арга хэмжээ: Орон нутгийн ИНБ-уудын оролцоо хамтын ажиллагаанд тулгуурлан жендэрийн боловсрол олгох, хэвшмэл ойлголт хандлагыг өөрчлөх сургалт, аяныг гэрээлэн гүйцэтгүүлэх | 2021-2024 | ОНТ 1.5 | Жендерийн тэгш бус байдлын индекс | 2020 | 0.825 | 0.826 | 2020 онд жендэрийн тэгш бус байдлын индекс 0,319 болсон байна. Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулсан Хэвлэл мэдээллийн ажилтнуудыг чадавхжуулах онлайн сургалтад 3 ажилтан хамруулсан. 2021 оны Жендерийн тэгш бус байдлын индексийн үзүүлэлт гараагүй байна. | 0 |
| **4.3 Хүний эрхийг дээдэлсэн амар тайван, аюулгүй нийгэм** | | | | | | | | | |
| **4.3** | Зорилго: Хууль сахиулах байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, гэмт хэргийн шийдвэрлэлтийн хувийг 2019 онд 86.5 байсныг 2024 онд 90-ээс дээш хувьд хүргэнэ. | 2021-2024 | 2035.0 | Гэмт хэргийн шийдвэрлэлтийн хувь | 2019 | 86.5 | 87 | Аймгийн хэмжээнд 2021 онд 193 гэмт хэргийг хэрэгсэхгүй болгох саналтай аймгийн прокурорын газарт хүргүүлж, 182 гэмт хэргийг яллах дүгнэлт үйлдүүлэх, яллагдагчаар татах саналтай прокурорын газарт хүргүүлж, 19 гэмт хэргийг харьяалалын дагуу шилжүүлж, нийт гэмт хэргийн 87.1 хувийг шийдвэрлэсэн. | 100 |
| 4.3.1 | Зорилт: Гэмт хэргийн гаралт 2019 онд 211 байсныг 2024 онд 10-аас доошгүй хувиар бууруулна. | 2021-2024 | 1276.8 | Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо | 2019 | 211 | 206 | Бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалд дүгнэлт хийж өсөлттэй байгаа тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр ажил зохион байгуулсаны үр дүнд тус аймагт 2021 онд 245 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдсанаас дээрэмдэх гэмт хэрэг 2 дахин, хулгайлах гэмт хэрэг 24.3 хувь, мал хулгайлах гэмт хэрэг 6.7 хувь, хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг 50 хувь, аймгийн төвд үйлдэгдсэн гэмт хэрэг 1.27 хувь, гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 27.5 хувь, зам тээврийн улмаас нас барсан хүн 83.3 хувь, эрүүлжүүлэгдсэн хүн 60.5 хувиар тус тус буурсан байна. | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4.3.1.1 | Арга хэмжээ: Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран архидан согтуурахтай тэмцэх орон нутгийн бодлого боловсруулан, хууль сахиулах байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх | 2021-2024 | ОНТ 10.0 | Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг (тоо) | 2019 | 55 | 53 | Аймгийн Засаг даргын захирамжаар аймгийн хэмжээнд сар бүрийн 1, 15, 25-ны өдрүүдэд “Архи, согтууруулах ундаа худалдаалах, түүгээр үйлчлэхгүй байх өдөр болгох тухай” шийдвэр гаргуулан хэрэгжүүлэн ажиллаж байна. Аймгийн ГХУСАЗСЗ, ЭМГ, Цагдаагийн газартай хамтран архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэдэг зорилтот бүлгийн 30 иргэнийг хамруулсан “Амьдрал сайхан” соён гэгээрүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж дээрх иргэдийг Нэгдсэн эмнэлгийн дүрс оношлогоо, сүрьеэ, сэтгэц, дотрын эмчид тус тус үзүүлэн 3 төрлийн шинжилгээнд хамруулж, архинд донтох өвчтэй 3 иргэний дүгнэлтийг гаргуулан архины албадан эмчилгээнд хамруулсан. 2021 онд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 89 бүртгэгдэж өмнөх оныхоос 34 хэргээр буюу 61.8 хувиар өссөн, эрүүлжүүлэгдсэн хүн 36.05 хувиар буурсан байна. | 0 |
| 4.3.1.2 | Арга хэмжээ: Цагдаагийн газрын хуучин барилгыг засварлаж, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдийг түр хамгаалах, иргэдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, мэдээллээр үйлчлэх төвийг байгуулж ажиллуулах | 2021-2024 | - | Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн бууралт (тоо) | 2019 | 9 | 8 | Цагдаагийн газрын хуучин барилгын хоёр өрөөг гэр бүлийн хүчирхийллийн хохирогч нарт тусламж үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний танхимыг байгуулах төслийг 2021 оны 36/88 дугаартай албан бичгээр аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд хүргүүлсэн. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 16 бүртгэгдэж 8 хэргээр | 0 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
